



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭДИЙН ЗАСГИЙГ
2014-2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ**



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ 2014-2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ



Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн "Орон нутгийн цогц хөгжил түншлэл" төслийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэв.

Хянасан: Ц.Ганболд - Аймгийн ЗДТГ-ын дарга
Эхийг бэлтгэсэн: Ч.Батсуурь - Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн ахлах мэргэжилтэн

..... хэвлэлийн компанид 1500 ширхэг хэвлүүлэв.
Цаасны хэмжээ А4, ... хэвлэлийн хуудас,

Арвайхээр хот
2014 он

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ 8

ХОЁР. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨӨЦ, БОЛОМЖ

2.1 АЙМГИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	10
2.2 АЙМГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН БАГТААМЖ, НӨӨЦ, БОЛОМЖ	17
2.3 АЙМГИЙН ЭДИЙН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУД	34

ГУРАВ. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУДЫГДУНД БА УРТ ХУГАЦААНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

3.1 ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР	35
3.2 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР	36
3.3 ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН САЛБАР	38
3.4 БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР	39
3.5 УУЛ УУРХАЙН САЛБАР	39

ДӨРӨВ. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА, МЕХАНИЗМ 41

ХАВСРАЛТ. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ 43

Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит IX хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа.

Энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулахдаа МҮИСургуулийн судалгааны багтай хамтран аймгийн зах зээлийн багтаамжийн судалгааг явуулж, түүнд үндэслэн эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг ойрын болон урт хугацаанд хөгжүүлэх бодлого, зорилтыг тодорхойлж, түүнийг төрийн түшээд, эрдэмтэн судлаачид, иргэд, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын дунд хэлэлцүүлэн тэдний санал зөвлөгөөг тусгасан.

Сүүлийн жилүүдэд аймгийн хөгжлийн түвшин, эдийн засгийн өсөлтийн хурд улсын хэмжээнд болон хангайн бүсийн хэмжээнд нилээд өндөр байгаа хэдий ч эдийн засгийнхаа бүтцийг сайжруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаа юм.

Аймгийн ДНБ-ийг салбараар нь авч үзвэл 2013 оны байдлаар ХАА-н салбарын бүтээгдэхүүн 156.3 тэрбум буюу 50.9 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 23.3 тэрбум буюу 7.6 хувь, худалдаа, үйлчилгээний салбар 127.2 тэрбум буюу 41.4 хувийг тус тус эзэлж байна. Эндээс дүгнэж хэлэхэд аймгийн хөгжилд оруулах эдийн засгийн салбаруудын хувь нэмэр ихээхэн ялгаатай төдийгүй хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээний салбараас бараг бүрэн хамааралтай болсон байна. 2000 ба 2001, 2010 онуудын аймгийн эдийн засгийн уналт ч үүнтэй холбоотой юм.

Ийнхүү аймгийн эдийн засгийн бүтцийг сайжруулах, олон салбарт эдийн засгийг хөгжүүлж, аймаг орон нутгийнхаа хөгжлийг түргэсгэх нь энэ бодлогын баримт бичгийн үзэл санаа юм.

Бид уламжлалт хөдөө аж ахуйн салбараас бэлтгэж байгаа түүхий эд, материалаа нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулж дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх, Монгол орны түүх соёлын өлгий нутаг, газар зүйн байршлын давуу талаа ашиглан аялал жуулчлалын төрлүүд, түүний дотор тусгай сонирхолын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх, жуулчдын зорин очих байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудын угтах орчныг тохижуулж, үйлчилгээг сайжруулах, аймгийн аялал жуулчлалын бүс нутгуудын дэд бүтцийг хөгжүүлэх замаар монгол орны аялал жуулчлалын төв төдийгүй ОХУ, БНХАУ-ыг холбосон аялал жуулчлалын босоо тэнхлэгийн төв болох зэрэг дунд болон урт хугацааны стратегийн зорилтуудыг уг бодлогын баримт бичигт дэвшүүлээд байна.

Үүний зэрэгцээ Өвөрхангай аймаг нь 6 аймагтай хиллэж байгаа, Монгол улсын төв хэсэгт байрлах байршлын давуу талаа ашиглан Арвайхээр - Гучин-Ус - Шивээхүрэн, Арвайхээр - Баянгол - Цогтовоо - Даланзадгад чиглэлийн хатуу хучилттай авто замын сүлжээг байгуулж



Өвөрхангай аймгийн Засаг дарга
Д.Тогтохсүрэн

гадаад зах зээлд гарах, хангайн бүсийн аймгуудыг хойноос урагшаа холбох, баруун аймгуудыг Улаанбаатар хот болон бусад аймгуудтай холбосон худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн төв болон хөгжих зорилт тавиад байна.

Аймгийнхаа эдийн засгийн нөөц боломжид тулгуурлан эдийн засгийн тэргүүлэх салбаруудаа хөгжүүлэх зорилтуудаа нийгэм, улс төрийн нөлөөллөөс хамааралгүй тогтвортой мөрдөж ажилласнаар төлөвлөлтийн урт хугацаанд Арвайхээр хот нь ХАА-н бүтээгдэхүүн, аялал жуулчлал, барилга, барилгын материалын худалдаагаар баруун болон хангайн бүсийг хангасан худалдаа үйлчилгээ, тээвэр логистикийн, Хархорин хот нь Монгол орны аялал жуулчлал, түүх соёлын төв хотууд болон хөгжих бөгөөд бусад сумдын хувьд дээрх 2 хотыг түшиглэн бие даан хөгжих эдийн засаг, санхүүгийн нөхцөл бүрдэнэ.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт голлох үүрэг гүйцэтгэх бөгөөд эхнээсээ аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулах талаар бизнес эрхлэгчдээс ажил хэрэгч санал ихээр гарч байгаад талархалтай байна.

Аймгийнхаа эдийн засгийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг сайтар судлан, салбарын бодлого шийдвэр, бизнесийнхээ үйл ажиллагаатай уялдуулан ажиллахыг төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, иргэн та бүхэнд уриалж байна.



Судалгааны багийн ахлагч,
МУИС-ийн Эдийн засгийн онолын тэнхмийн
профессор, эдийн засгийн ухааны доктор
Ч. Хашчулуун

нэмэгдүүлэхэд чиглэсэн, салбар болон салбар дундын бодлогыг зангидсан, аймгийн эдийн засгийн хөгжлийн урт хугацааны нэгдсэн бодлого боловсруулах шаардлага тулгараад байна.

Сүүлийн жилүүдэд Өвөрхангай аймгийн эдийн засгийн өсөлт эрчимжиж, Хангай бүсийн дотор болон улсын хэмжээнд тэргүүлж байна. Энэхүү өндөр өсөлтийн нэг онцлог нь гэвэл аль нэг уурхай эсвэл салбарын дагнасан хөгжлөөс илүү аймгийн ДНБ-ий бүтэц ч Хангайн бүсийн дотор хамгийн боловсронгуй болж, нэг салбар (ХАА) давамгайлсан бус, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээ, аж үйлдвэр зэрэг олон салбарууд хөгжиж байгаатай холбоотой.

Гэхдээ энэ хөгжлөө эрчимжүүлэхийн тулд аймгийн зах зээлийн цар хүрээнд цаашид гарах, шинэ зах зээлтэй болох, шинэ тээврийн гарцтай болох, шинэ бараа бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох нь чухал. Иймээс энэхүү өсөлтийн эрчийг алдагдуулахгүй, гол зах зээлийн багтаамж, нөөц бололцоог судласны үндсэн дээр аймгийн цаашдын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг гаргах, үүнд улсын, аймгийн, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх нь амжилтын үндэс болно гэж үзэж эдийн засгийн ухааны доктор Х.Цэвэлмаа, докторант Т.Оюунбаатар, эдийн засгийн ухааны магистр Г.Нямбаяр болон миний бие орсон МУИС-ийн Эдийн засгийн онолын тэнхмийн судалгааны баг Өвөрхангайн аймгийн зах зээлийн багтаамжийг судлаж, бүсчилсэн хөгжлийн эдийн засгийн шинжлэх ухааны хамгийн сүүлийн үеийн судалгааны аргууд, загвар, тооцооны аргачлалыг ашиглаж, аймгийн зах зээлийн багтаамж, цаашдын хандлага, нөөц бололцоонд тулгуурласан хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг гаргасан судалгаа, зөвлөмжийг бэлтгэсэн.

Эдгээр тооцооны аргуудын зарим нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн судалгаанд төдийлөн хэрэглэж байгаагүй зах зээлийн потенциалын үнэлгээ, эрэлтийн таталтын тооцоо, боломжит борлуулалтын тооцоо зэрэг байгаа юм.

Тус судалгаанаас гарсан судалгааны дүн, тоо баримтууд, зөвлөмжүүд бүсчилсэн хөгжлийн чиглэлээр ажиллаж байгаа бусад судлаач, эрдэмтэд, Засгийн газар, аймгийн удирдлага бүс нутгийн хөгжлийн бодлогыг боловсруулахад суурь судалгаа болж, Өвөрхангай аймгийн хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулна гэж найдаж байна.

Эрчимтэй хөгжсөн Европын улсууд, Япон, Сингапур, Тайвань зэрэг орнууд улс орныхоо хэмжээнд нөөц, бололцоогоо сайтар судалж, хөгжлийн төлөвлөлтийг зохион байгуулан бодлого дунд болон урт хугацаанд хөгжлийн тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлж чадсан нь тэдний хурдтай хөгжлийн үндсэн хөшүүрэг байв. Дэлхийн эдийн засагт хүч түрэн орж ирж байгаа БНХАУ, БНЭУ зэрэг хөгжиж байгаа улсууд ч эдийн засаг, нийгмээ маш сайн төлөвлөж хөгжүүлэх төрийн тогтолцоотой байгаа нь энэхүү амжилтын үндэс болсоор байна.

Үүний хүрээнд орнууд бүс нутгийн хөгжилд онцгой анхаарч, бүс нутгийн стратегийн төлөвлөлтийн тогтолцоог түлхүү хөгжүүлж байна. Тухайлбал, Турк улс, БНСУ, Европын Холбооны улсууд бүсчилсэн хөгжлийн хүрээнд маш өндөр үр дүнд хүрч байна.

Ийнхүү олон улсын туршлага, Монгол улсын өөрийн хөгжил, өөрчлөн шинэчлэгдэж байгаа нөхцлийг харгалзан Өвөрхангай аймгийн зах зээлийн багтаамжийг судлах, хөгжлийн бодлого, стратегийг шинэчлэн хувийн хэвшлийн боломжийг улсын хөрөнгө оруулалт, төсөвтэй уялдуулан эрэмбэлэн шийдвэрлэж, бүс нутгийн хөгжлийн хурдныг ахиулан иргэдийнхээ амьжиргааг сайжруулах, амьдралын чанарыг дээшлүүлэх, бизнесийн өрсөлдөх чадвараа

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 09/07

Арвийхээр

Бодлогын баримт бичиг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 "а", "е" заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 он хүртэл хөгжүүлэх бодлогын баримт бичгийг хавсралт ёсоор баталсугай.

2. Эдийн засгийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан дунд болон урт хугацааны стратегийн зорилтуудыг улсын болон бүсийн хөгжлийн бодлогод тусгах, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нөөцийг оновчтой хуваарилж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Тогтохсүрэн/-д даалгасугай.

3. Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж, урт хугацаанд тогтвортой мөрдөж ажиллахад идэвхи санаачилгатай хамтран ажиллахыг иргэд, аж ахуй нэгж, байгууллага болон улс төрийн намуудад уриалсугай.



ДАРГА Д. ГАНБОЛД

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ 2014-2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн үеийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлого /2007-2015 он/ болон аймгийн салбаруудын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдийг судлан Өвөрхангай аймгийн зах зээлийн багтаамжийн судалгааг хийж, түүний үндсэн дээр аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулав.

Сүүлийн 40-50 жилийн хугацаанд эрчимтэй хөгжсөн Япон, Сингапур, Тайвань зэрэг орнууд хөгжлийн эхний үе шатандаа улс орныхоо хэмжээнд маш сайн уялдуулсан, нэгдсэн төлөвлөлтийг төрөөс зохион байгуулан, хөгжлийн бодлогоо 4-5 ба түүнээс дээш жилийн хугацаагаар нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөртэйгээр амжилттай хэрэгжүүлж чадсан нь тэдний хурдтай хөгжлийн төрийн үндсэн хөшүүрэг байв. Мөн эдийн засгийн цар хүрээ, өсөлтийн хэмжээгээрээ дэлхийн эдийн засагт хүч түрэн орж ирж байгаа БНХАУ, БНЭУ зэрэг улс орон ч эдийн засаг, нийгмээ маш сайн төлөвлөж хөгжүүлэх төрийн тогтоолоотой байгаа нь энэхүү амжилтын үндэс болсоор байна. Европын Холбооны улсууд дунд хугацааны хөгжлийн стратегийн баримт бичгүүдийг боловсруулж, тэдгээрийг 5 жил тутам тодотгон хэрэгжүүлж байгаа нь дунд хугацааны стратеги, төлөвлөлт зайлшгүй хэрэгцээтэй болохыг нотлон харуулж байна.

Үүний хүрээнд өндөр хөгжилтэй болон хөгжиж байгаа орнууд бүс нутгийн хөгжилд онцгой анхаарч, бүс нутгийн стратегийн төлөвлөлтийн тогтоолоог түлхүү хөгжүүлж байна. Тухайлбал, Турк улс, БНСУ, Европын Холбооны улсууд бүсчилсэн хөгжлийн хүрээнд маш өндөр үр дүнд хүрч байна.

Монгол улстай ижил хуучин социалист тогтоолоонд байсан улсуудаас Польш зэрэг улс бүсчилсэн хөгжилд түлхүү анхаарч Бүсчилсэн хөгжлийн яамыг хүртэл байгуулж амжилттай ажиллаж байна.

Ийнхүү олон улсын туршлага, Монгол улсын өөрийн хөгжил, өөрчлөн шинэчлэгдэж байгаа нөхцлийг харгалзан Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегийн төслийг шинэчлэх, хөгжлийн зорилтуудыг өөрийн нөөц бололцоог дайчлах замаар, хувийн хэвшлийн боломжийг улсын хөрөнгө оруулалт, төсөвтэй уялдуулан эрэмбэлэн шийдвэрлэж, бүс нутгийн хөгжлийн өнөөгийн хурдацыг ахиулан, түвшинг үлэмж нэмэгдүүлэх улмаар иргэдийнхээ амьжиргааг сайжруулах, амьдралын чанарыг

дээшлүүлэх, бизнесийн өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхэд чиглэсэн, салбар болон салбар дундын бодлогыг зангидсан, аймгийн хөгжлийн дунд, урт хугацааны нэгдсэн аймгийн стратеги бодлого, төлөвлөгөөг боловсруулах шаардлага тулгараад байна.

Аймаг, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийг хийхэд УИХ-д өргөн баригдаж, 2014 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр жагсаалтанд орсон Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн төсөл батлагдснаар цаашид аймаг болон улсын хэмжээнд төлөвлөлтийг хийх нэгдсэн загвар, бодлогын эрх зүйн орчин бүрэлдэнэ.

Одоогийн байдлаар Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа хувилбарт “хөгжлийн бодлого төлөвлөлт” гэж Монгол улсын хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, түүнд шаардагдах нөөцийн хуваарилалтыг судалгаа, шинжилгээнд үндэслэн төлөвлөх үйл явцын нэгдлийг;

- **“хөгжлийн бодлогын баримт бичиг”** /цаашид “бодлогын баримт бичиг” гэх/ гэж хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх үе шат, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг;

- **“бүсчилсэн хөгжлийн бодлого”** гэж хөгжлийн үзэл баримтлалд суурилсан, бүсчиллээр дамжуулан орон нутгийн эдийн засаг, нийгэм, соёл, хүн амын хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдааг хангах замаар орон нутгийн хөгжлийг дэмжих бодлогын баримт бичгийг;

- **“аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт”** гэж хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн бодлогод суурилсан, орон нутгийн онцлогийг харгалзан эдийн засаг, нийгмийн хөгжлийг тодорхой түвшинд хүргэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон бодлогын баримт бичгийг;

- **“Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”** гэж бүсчилсэн хөгжлийн бодлого болон аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод үндэслэн, нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг тусгасан, орон нутгийн хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэл, зорилтыг агуулсан бодлогын баримт бичгийг хэлнэ гэж тус тус заасан байна.

Эдийн засгийн бодлогын баримт бичгийг боловсруулахад дараах зарчмуудыг баримталлаа:

- Дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага болон өөрийн орны хөгжлийн онцлогийг харгалзсан байх;

- Нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэнцвэрт байдалд суурилан тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн байх;

- Салбар хоорондын болон бүсчилсэн хөгжлийн уялдааг хангасан байх;

- Орон нутгийн зах зээлийн нөөц, боломж дээр тулгуурласан байх;

- Судалгаа, шинжилгээнд суурилсан байх;

- Мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангасан байх;

- Тоон мэдээлэл чанарын үзүүлэлтээр баталгаажсан байх;


Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегийн зорилго нь аймаг, бүс нутгийн хүрээнд салбаруудын харилцан уялдаа бүхий багц бодлого, арга хэмжээг боловсруулж эрэмбэлэн хэрэгжүүлэх явдал юм. Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратеги нь шинжилгээ хийгдсэн, бодлогын саналын үндэслэлийг сайн гаргасан, үр дүнд чиглэсэн, санхүүгийн эх үүсвэрийн хүрээнд багтсан, зардал төсөвлөгдсөн, бодитой байх шаардлагатай юм.

Стратегийн төлөвлөлтийг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилго, зорилтыг гадаад орчны нөхцөл байдалтай нийцүүлэн

тодорхойлж, салбарын бодлогыг өөр хооронд нь уялдуулан, улсын хөгжлийн зорилтод үзүүлэлт болон макро эдийн засгийн гол үзүүлэлтийг тооцсон байх шаардлагатай.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегийг боловсруулахад нийтлэг арга зүйг онолын хувьд судлахаас гадна дэлхийн бусад орны туршлагыг судалж үзлээ. Тухайлбал, АНУ, Малайз, Казахстан, Катар, Саудын Араб зэрэг орны дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө, түүнийг боловсруулж байгаа арга зүйг судалсан. Тэдний боловсруулсан арга зүйн гол онцлог нь өнөөгийн байдлаа маш сайн судлан мэдэж, хөгжлийн урт хугацааны эрхэм зорилго, үнэт зүйлст хүрэх дунд хугацааны стратеги, төлөвлөгөөгөө боловсруулсан байна.

Аймгийн хөгжлийн бодлогын үйл ажиллагааг нарийвчлан гаргах нь бодлогын баримт бичгийн салшгүй нэг хэсэг. Санал болгож буй үйл ажиллагааг хувийн хэвшил, төрийн ба төрийн бус байгууллагууд дэмжиж, харилцан зөвшилцөж хөгжүүлэх сонирхол их байх нь чухал. Оролиогч талуудын сонирхол нийцэж байвал сонгосон салбарыг хөгжүүлэх хүний нөөц, эдийн засаг, санхүү, менежмент, маркетинг, хамтын ажиллагаа, тогтвортой бизнесийн орчинг бүрдүүлэхээр ажиллахад харьяангуй хялбар байх болно.




ХОЁР. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН НӨӨЦ, БОЛОМЖ

2.1 Аймгийн макро эдийн засгийн өнөөгийн байдал

Монгол улсын эдийн засагт Хангайн бүсийн эзлэх хувь 2007 оноос буурсаар байгаа бол, харин Хангайн бүсийн эдийн засагт Өвөрхангай аймгийн эзлэх хувь сүүлийн жилүүдэд аажим боловч өссөөр байна.

Зураг 2.1. МУ-ын эдийн засгийн өсөлт, Хангайн бүс, Өвөрхангай аймгийн ДНБ-ий эзлэх хувь




Эх сурвалж: YCX, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

Аймгийн хөгжлийн өнөөгийн түвшин улсын болон бүсийн хэмжээнд дараах байдлаар тодорхойлогдож байна.

Улаанбаатар, Орхон, Дархан-Уул аймаг зэрэг уул уурхай, хот суурин газрын аж ахуйн бүтэц давамгайлсан аймгийг эс тооцвол, ДНБ-ний хэмжээгээр тус аймаг улсад тэргүүлэх аймгуудын тоонд орж байна.

Зураг 2.2 Дотоодын нийт бүтээгдэхүүн, аймгаар, 2012, 2013 он



Эх сурвалж: YCX, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

Аймгийн хөгжлийн түвшин, эдийн засгийн өсөлтийн хурд улсын хэмжээнд болон хангайн бүсийн хэмжээнд нилээд өндөр байна.

Оны үнээр тооцсон аймгийн ДНБ 3 жилийн дотор буюу 2010 оноос 2013 оны хооронд 3 дахин нэмэгдэж, 103.0 тэрбум төгрөгөөс 2013 онд 307.0 тэрбум болж өсчээ.


Аймгийн ДНБ-ийг салбараар нь авч үзвэл 2013 оны байдлаар ХАА-н салбарын бүтээгдэхүүн 156.3 тэрбум буюу 50.9 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 23.3 тэрбум буюу 7.6 хувь, худалдаа, үйлчилгээний салбар 127.2 тэрбум буюу 41.4 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн эдийн засаг өсөж байгаа хэдий ч эдийн засгийн салбаруудын оруулах хувь нэмэр ихээхэн ялгаатай байгаа юм.

Салбаруудын өсөлтөд үзүүлж буй хувь нэмрийг харахад аймгийн эдийн засаг хөдөө аж ахуйн салбараас бараг бүрэн хамааралтай байсан бөгөөд 2000, 2001, 2010 онуудын уналт ердөө л хөдөө аж ахуйн уналтаас шалтгаалжээ.

Сүүлийн жилүүдэд аймгийн эдийн засгийн өсөлт дундажаар жилд 45 хувьд хүрч, Хангай бүсийн дотор тэргүүлж байгааг өндөр өсөлтийн олон хүчин зүйлс хангаж байгаа бөгөөд аймгийн ДНБ-ий бүтэц ч Хангайн бүсийн дотор хамгийн боловсронгуй болж, зөвхөн нэг салбар (ХАА) давамгайлсан бус, худалдаа үйлчилгээ, аж үйлдвэр, барилгын салбар хөгжсөнтэй холбоотой бөгөөд үүнийгээ урт хугацаанд улам сайжруулах, ХАА-н салбараас бусад салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зураг 2.3 Аймгийн ажил эрхлэлт ба иалингийн эзлэх хувь, салбараар, 2013 он



Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэс, судалгааны багийн тооцоо

Өвөрхангай аймгийн ажил эрхлэлт ба иалингийн хувийн жинг авч үзэхэд хөдөө аж ахуйн салбарын ажил эрхлэлт нийт ажил эрхлэлтийн 58.8 хувийг, харин иалингийн 42.8 хувийг эзлэн эдийн засагт гол үүрэг гүйцэтгэж байгаа бол боловсрол (5.2% ба 11.1%), төрийн удирдлага (3.8% ба 8.1%), барилга (4.1% ба 6.6%)-ын салбар нь аймгийн эдийн засагт ажиллах хүч ба иалингийн эзлэх хувийн жингээрээ удаалж байна. Харин боловсруулах үйлдвэр (2.0% ба 1.9%), үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа (0.2% ба 0.2%) байгаа нь цаашид нэмэгдүүлэх шаардлагатай байна. Аймгийн хэмжээнд бөөний худалдаа (9.3% ба 5.3%) ба барилгын салбар (4.1% ба 6.6%) нь ажил эрхлэлтэд нөлөөлөхүйц хувийн жинг эзэлж байна.

Өмнө нь буюу 2000 оны үеэр аймгийн хөдөө аж ахуйн салбарын дийлэнхийг /90 гаруй хувь/ мал аж ахуйн салбар бүрдүүлдэг учраас мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн өсөлт бууралт л өнөөг хүртэлх аймгийн эдийн засгийн өсөлт, бууралтыг тодорхойлж байжээ.

Харин өнөөгийн нөхцөлд уламжлалт ХАА-н салбарын эзлэх хувийн жин багасаж, төрийн байгууллагын худалдан авалт, худалдаа, зочид буудал, зоогийн газарт харъяалагдах салбарын хувийн жин их байж, аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жин нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа худалдаа, зочид буудал буюу тээвэр логистик, аялал жуулчлалтай холбоотой салбарын өсөлт нийт ДНБ-ий өсөлтөд өндөр хувийг эзэлж байна.

ДНБ-ий шинжилгээг хийхэд судалгааны багаас Shift-Share аргачлалыг үндэслэн аймгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийн судалгааг хийсэн. Тус аргачлалын онолог гэвэл аймгийн ажил эрхлэлтийн тоог үндэслэн ДНБ-ийн өсөлтийг задлан шинжилж, 3 хэсэг компонентээр авч үздэг. Үүнд нийт эдийн засгийн өсөлтөд макро түвшний үндэсний өсөлтийн үүрэг хувь нэмэр, аймгийн салбарын бүтэц, өрсөлдөх чадвар гэсэн гурван компонентээр шинжилгээ хийдэг.

Өвөрхангай аймагт гарсан өөрчлөлтийг харахад нийтдээ 2003-2013 онд сонгосон салбаруудад ажил эрхлэлт 8800 ажиллагчдын тоогоор нэмэгджээ. Таамаглалаа ашиглан салбарын хольцыг тодорхойлоход ХАА-н салбарын ажиллагчдын тоо өнгөрсөн 10 жилийн хугацаанд 10609 ажиллагчаар багассан. ХАА-н ажил эрхлэлтийн их хэмжээний бууралт нь нийт сонгосон салбарын ажил эрхлэлтийг 7342 ажиллагчаар буурахад нөлөөлсөн боловч, нөгөө талаас аж үйлдвэр, барилга, үйлчилгээ зэрэг салбаруудад ажил эрхлэлт ихээхэн нэмэгдэж, нийт дүнгээр ажил эрхлэлт өссөн байна. Салбарын бүтцэд барилгын салбарын эзлэх хувь, ажил эрхлэлт илүү байжээ. Харин бусад салбарт өсөлтийн хувь харилцан адилгүй байгаа ч нийт дүнгээрээ ажиллагчдын тоо өсчээ. Цаашилбал салбарын ажил эрхлэлтийн хувь, ажиллагчдын тоог тодорхойлж үзэхэд өнгөрсөн 10 жилийн хугацаанд 2329 ажиллагчаар ажил эрхлэлт нэмэгдсэн байгаа нь аймгийн хувьд өрсөлдөх сайтай гэж гарсан байна.


Өөрөөр хэлбэл өнгөрсөн хугацаанд тус аймагт шинээр ажлын байр бий болгох олон салбарыг татаж чадсан байна гэж үзнэ.

Цаашид аймгийн ажил эрхлэлтийг эрчимтэй өсгөхийн тулд эхний ээлжинд аж үйлдвэр, барилгын салбар голлох үүрэг гүйцэтгэнэ. Харин нийт ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд хөдөө аж ахуй, тээвэр логистикээрэг салбаруудыг бодлогоор хөгжүүлэх шаардлагатай байна.

Санхүүгийн зах зээл

Аймгийн санхүүгийн зах зээлийн боломж, эдийн засгийн өндөр өсөлт Өвөрхангай аймагт хийгдэж буй хөрөнгө оруулалттай уялдаатай байгаа. Нийт хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн жилүүдэд эрчимтэй нэмэгдэж, 2005 онд 3.3 тэрбум байсан хөрөнгө оруулалтын хэмжээ 2013 оны байдлаар 76.9 тэрбум төгрөгт хүрч, 2005 онд аймгийн ДНБ-ий 5.6 хувьтай тэнцэх хөрөнгө оруулалт хийгдэж байсан бол 2013 онд 25.1 хувьтай тэнцэж байна.

Зураг 2.4. Өвөрхангай аймгийн хөрөнгө оруулалт сая төгрөгөөр, 2005-2013 он




Эх сурвалж: Өвөрхангай аймгийн статистикийн мэдээлэлд үндэслэн тооцов.

Ялангуяа 2013 онд нийт хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдсэн бөгөөд өмнөх онуудтай харьцуулахад 89.1 хувь буюу 36.2 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Тухайн онд хөрөнгө оруулалтын ажлын 42.8 хувийг зам засвар арчлалтанд зарцуулжээ. Үүнтэй холбоотойгоор барилга үгсралт, их засварын ажлын эзлэх хувь 2005-2013 онд 33.9-76.9 хувь болж өссөн. Энэхүү өндөр хэмжээний хөрөнгө оруулалтын өсөлт аймгийн эдийн засгийн өсөлтийн гол эх үүсвэрүүдийн нэг болсон байна.

Зураг 2.5. Хадгаламжийн хэмжээ /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

Хадгаламжийн хэмжээ 52.0 тэрбум төгрөгт хүрсэн нь Хөвсгөл аймгийн дараа эрэмбэлэгдэх бүсэд тэргүүлэх үзүүлэлт болж байгаа бөгөөд орлогын өсөлт, хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн үр дүнд хадгаламжийн хэмжээ нь Хангайн бүсийн аймгуудын дунд тэргүүлэх хэмжээнд хүрч, Баянхонгор, Булган, Архангай аймгаас нилээд өндөр болсон.

Энэ бол аймгийн хэмжээнд санхүүгийн зах зээл идэвхтэй хөгжиж, иргэдийн хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаагийн шинж юм.

Цаашид аймгийн өөрийн зах зээлийн хөгжилд чухал хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлж байгаа юм. Санхүүгийн зах зээлийн хөгжлийн бас нэгэн чухал үзүүлэлт нь аймгийн хэмжээнд зээлийн үлдэгдлийн хэмжээ, аймгийн хэмжээгээр иргэд, аж ахуйн нэгжүүд хэр их хэмжээний зээл авч хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дэмжиж байгааг харуулна.

Зураг 2.6. Аймгийн иргэдийн зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

2010 онд аймгийн хэмжээгээр зээлийн үлдэгдэл 35.0 орчим тэрбум төгрөг байсан бол хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн үр дүнд зээлийн хэмжээ нь Хангайн бүсийн аймгуудын дунд тэргүүлэх хэмжээнд буюу 127.0 тэрбум төгрөгт хүрч, Хөвсгөл, Баянхонгор, Булган, Архангай аймгаас нилээд өндөр болсон.

Зээл олгоход чанаргүй зээл хэр их байгаа нь бас чухал үзүүлэлт. Өвөрхангай аймгийн зах зээлийн багтаамж, цаашдын өсөлтөнд санхүүгийн зах зээлийн хөгжлийн түвшин өндөр ач холбогдолтой бөгөөд бүсийн хэмжээнд хамгийн бага чанаргүй зээлийн хувьтай байгаа нь санхүүгийн хувьд аймгийн иргэдийн орлого тогтвортой, банкны салбар сайн ажиллаж байгаагийн шинж гэж үзэж болно.

Зураг 2.7. Чанаргүй зээлийн хэмжээ, сая төгрөгөөр, 2010-2013 он



Эх сурвалж: УСХ, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

2012-2013 оны хооронд чанаргүй зээлийн хэмжээ Хангай бүсийн олон аймагт өссөн байхад, Өвөрхангай аймагт тус үзүүлэлт 2010 оноос тууштай буурч, хамгийн доод түвшинд очиж нийт хэмжээгээр бараг 5 дахин буурсан.

Энэ бол санхүүгийн хувьд маш чухал үзүүлэлт бөгөөд цаашид эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх, зээл олгоход санхүүгийн нөөц бололцоо сайн байна.

Хүн ам, хөдөлмөрийн нөөц, ажилгүйдэл

Өвөрхангай аймаг нь хүн амын тоогоороо улсдаа Хөвсгөл аймгийн дараа 2 дугаарт орж байна. Монгол улсын нийт хүн амын 3.9 хувь, хангайн бүсийн хүн амын 19.9 хувь Өвөрхангай аймагт амьдарч байна. 2013 оны байдлаар суурин хүн амын тоо 111824 болж, өмнөх оны мөн үеэс 1.16 хувиар өссөн нь улсын дунджаас 1.02 пунктээр бага, хангайн бүсийн дунджаас 0.5 пунктээр өндөр байна.

Байршлаар авч үзвэл аймгийн төвд 28508 хүн, сумын төвд 32811 хүн, хөдөөд нийт хүн амын 45.2 хувь буюу 50505 хүн амьдарч байна.

Нийт хүн амын 49.7 хувь буюу 55596 нь эрэгтэйчүүд, 50.3 хувь буюу 56228 нь эмэгтэйчүүд байна. Хүйсийн харьцаагаар 100 эмэгтэйд 99 эрэгтэй ногдож байна.

Нийт хүн амын 28.9 хувийг 15 хүртэлх насны хүүхэд эзэлж байгаа бол 4.3 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна.

Хүн ам зүйн ачааллыг авч үзвэл хөдөлмөрийн насны 100 хүнд хөдөлмөрийн бус насны 49-50 хүн ногдож байна.

Үүнээс хүүхэд насны хүн ам зүйн ачаалал 43.3 байсан бол хөгшин насны хүн ам зүйн ачаалал 6.5 байна.

Зураг 2.8. Өвөрхангай аймгийн хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь /1956-2013 он/



Эх сурвалж: Өвөрхангай аймгийн статистикийн мэдээлэлд үндэслэн тооцов.


Өвөрхангай аймгийн хүн амын өсөлтийн хурд төрөлт өндөр байх үед буюу 1956-1989 оны хооронд өндөр, ялангуяа 1963-1969 оны хооронд жилд дунджаар 3.3 хувийн өсөлттэй байжээ.

1989-2000 оны хооронд жилд дунджаар 1.4 хувь, 2000-2010 оны хүн амын тооллогын хооронд хүн амын өсөлт жилд дунджаар 0.91 хувиар буурсан.

1979 онд Өвөрхангай аймгийн бүх сумдад хүн амын эерэг өсөлттэй байсан (Хавсралт 1) бол 1989 онд Баян-Өндөр, Есөнзүйл, Өлзийт, Сант, Тарагт, Хайрхандулаан сумд болон 2000 онд Бүрд, Хужирт сумдын хүн амын өсөлтийн хувь буурсан. 2010 оноос эхлэн ихэнх сумдын хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь багассан. 2013 оны байдлаар Баян-Өндөр (-3.88), Есөнзүйл (-3.17) сумын хүн амын тоо бусад сумдаас харьяангүй илүү буурсан бол Бат-Өлзий (5.81), Зүүнбаян-Улаан (7.14) сумын хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь хамгийн өндөр байна.

2013 оны байдлаар Өвөрхангай аймагт 2783 хүүхэд төрж, 1000 хүнд ногдох төрөлт 27.3, 725 хүн нас барж, 1000 хүн ногдох нас баралт 7.1 буюу хүн амын цэвэр өсөлт 20.2 байна.

Зураг 2.9. Төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор, /1957-2013 он/



Эх сурвалж: УСХ, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

1990 оноос хойш сумдын хүн амын өсөлтөнд ердийн өсөлтөөс илүү механик өсөлтийн нөлөө их байна. Аймгийн хэмжээнд 1990 оноос хойш ердийн өсөлт эерэг байгаа бол механик өсөлт сөрөг байна. (Зураг 2.9)

1969, 1989, 2000 оны тооллогоор Өвөрхангай аймгийн хүн ам залуу насны бүтэцтэй байсан бол 2010 болон 2013 онд 0-14 насны хүн амын эзлэх хувь 29 орчим хувь болж буурсан нь насны бүтэц идэрших хандлагатай гэдгийг харуулж байна. (Зураг 2.10) Энэ үед хөдөлмөрийн насны хүн амын тоо их байх тул аймгийн зүгээс залуу боловсон хүчнээ бэлтгэх, ажлын байр нэмэгдүүлэх тал руу түлхүү анхаарсан боллого явуулах хэрэгтэй болж байна. Гэхдээ хөдөлмөрийн насны хүн ам дотор ажилгүй хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан болон сурагчид орж байгааг анхаарах хэрэгтэй.

Хүснэгт 2.1 Хөдөлмөрийн насны хүн ам 2010-2013 он /сонгосон үзүүлэлтээр/

Үзүүлэлт	2010	2011	2012	2013
Хөдөлмөрийн насны нийт хүн ам	69805	72675	71662	72348
Ажиллагсад	49614	47702	48409	49865
ХЭА-нд бүртгэлтэй ажилгүйчүүд	2230	2175	1854	1822
Ажил эрхлээгүй хүн ам	8323	8296	7691	6059
Суралцагчид	8029	10789	9821	10765
Хөдөлмөрийн чадваргүй хүн ам	3839	3713	3893	3889

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн статистикийн мэдээлэл

Хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулдаг гол үзүүлэлтийн нэг нь хүн амын нас, хүйсийн суварга юм. 1969 оны суварга 0-9 насанд өргөн байгаа хүн амын төрөлт өндөр, нас баралт тогтвортой байсан буюу 1963-1969 оны хооронд хүн амын жилийн дундаж өсөлт 3.3 хувь байсантай холбоотой.


1989 оны хүн амын нас, хүйсийн суварга нь өмнөх оны төрөлтийн өндөр түвшний нөлөөгөөр

хүн амын бүтэц залуужих хандлагатай байсан бол 2000 онд суваргыг харахад 10-14 насны хүн амын хүн амын хэсгээрээ өргөн байгаа нь 1990 оноос өмнөх төрөлтийн өндөр түвшний нөлөө, 0-9 насныхан нарийссан нь 1990 оноос хойшхи төрөлтийн бууралт болон шилжих хөдөлгөөнтэй холбоотой. Харин 2013 оны хувьд хүн амын бүтэц илэрших хандлагатай болсон байна.

Энэ үед хөдөлмөрийн насны нийт хүн амд эзлэх хувь 66.8 байгаа нь хөдөлмөрийн нөөц их болсныг илтгэж байна.

Өвөрхангай аймгийн хувьд өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд хүн амын өсөлт маш бага байгаа нь хүн амын өсөлтийг дэмжих, хүн амын дотоод шилжих хөдөлгөөний асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй байгааг харуулж байна.

Зураг 2.10. Хүн амын нас, хүйсийн суварга /1969, 1989, 2000, 2013 он/




Эх сурвалж: Өвөрхангай аймгийн статистик мэдээлэлд үндэслэн тооцов.

Боловсрол нь хүмүүсийн ажиллаж, амьдрах чадавхи, хүмүүн капиталд оруулсан хөрөнгө оруулалтын үр ашгийг харуулах чухал үзүүлэлт юм. 2013 оны байдлаар аймагт Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 1 төв - 1243 оюутантай, ерөнхий боловсролын 29 сургууль - 1093 багш, 20817 суралцагчидтай, 33 цэцэрлэг - 161 багш, 7799 хүүхэдтэйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

2010 оны хүн амын тооллогын үр дүнгээс харахад аймгийн нийт хүн амын 7.7 хувь нь дээд боловсролтой, хүйсээр авч үзвэл эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс 4.3 пунктээр өндөр байна. 2000 онтой харьцуулахад дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь нэмэгдсэн. Техникийн болон тусгай мэргэжлийн хүмүүсийн эзлэх хувь буурсан. Хоёр тооллогын хооронд хүн амын боловсролын түвшинд ахиц гарсан ч бодит байдалд арай өөр дүр зураг харагдаж байна.

Зураг 2.11 Ажилгүйдүүд, боловсролын түвшингээр, /2013 он/



Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэс, Статистикийн эмхэтгэл, 2013 он

2013 оны байдлаар Өвөрхангай аймагт бүртгэлтэй 1822 ажилгүйдүүд байна. Боловсролын түвшингээр нь авч үзвэл ажилгүйдүүдийн 41 хувь буюу 745 хүн бүрэн дунд боловсролтой байсан. Анхаарал татсан нэг үзүүлэлт нь дээд боловсролтой ажилгүйдүүд 17 хувь буюу 312 хүн ажилгүйдүүдийн эгнээнд байна.

Үүнээс үзэхэд, цаашид техникийн болон мэргэжлийн чиглэлийн боловсролыг анхаарах шаардлагатай байна гэж хэлж болно. Тус хувь өнгөрсөн 10 жилд 2.6 хувь болж буурсан нь цаашид энэ чиглэлээр үйлдвэр, аж ахуйг хөгжүүлэхэд боловсон хүчин талаас хүндрэл учруулж болзошгүй.

2.2 Аймгийн зах зээлийн багтаамж, нөөц боломж

2.2.1 Зах зээлийн нийт багтаамж

Өвөрхангай аймгийн зах зээлийн багтаамжийг тооцоход, бүс нутгийн зах зээлийн багтаамжийн томъёогоор ашиглаж тооцов. Үүнийг дараах байдлаар тооцдог бөгөөд голлох экспортын зах зээлийн төлөв, худалдааны боломж зэргийг ашиглан шинжилгээ хийдэг. Үүнд MP бол аймгийн зах зээлийн багтаамжийг харуулж байгаа.

$$MPi = \sum_{j=1}^n \left(\frac{Mj}{Dij} \right)$$

Өвөрхангайн аймгийн өөрийн зах зээлээс гадна аймгийн экспортын гол зах зээлүүдийн шинжилгээ хийхэд аймгийн зах зээлийн багтаамжийг 291.0 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа дүн гарсан бөгөөд аймгийн экспортын хувьд Баянхонгор, Өмнөговь, Улаанбаатар хот гол зах зээл гэж гарсан байна.

Орон нутгийн худалдаанд оролиогчдыг (зах зээлийн хамралтын талбайг) дараах томъёогоор тооцон үнэлгээ хийсэн.

$$TAC_{ij} = \frac{AS_{ij}}{(AS_{sj}/P_s)/(Y_c/Y_s)}$$

Энд TAC_{ij} нь орон нутгийн худалдаанд оролиогчид, AS_{ij} нь i бүсийн /хангайн бүс/ j салбарын /бөөний болон жижиглэн худалдааны/ борлуулалтын орлого, AS_{sj} нь s орон нутгийн /Өвөрхангай аймаг/ j салбарын /бөөний болон жижиглэн худалдааны/ борлуулалтын орлого, P_s нь аймгийн хүн ам, Y_c нь хангайн бүсийн нэг хүнд ногдох орлого, Y_s нь аймгийн нэг хүнд ногдох орлого.

Хэрэв орон нутгийн худалдаанд оролиогчдын тоо нь тухайн орон нутгийн хүн амаас давбал тухайн орон нутаг гадагшаа худалдаа хийж чадах, эсвэл орон нутгийн оршин суугчдын зардлын хэв маяг бүс нутгийн дундажаас илүү гэсэн үг юм. Өвөрхангайн аймгийн нийт зах зээлийн багтаамж, түүний хамрах хүрээг тооцооход дараах байдалтай байна. Худалдааны бүсийн

шинжилгээгээр эрэлтийн хүчин зүйл /pull factor/ болон орон нутгийн худалдаанд оролиогчдыг авч үзэн тухайн орон нутгийн эрэлтэнд мэдэгдэхүйц нөлөөтэй бизнес, эсвэл арилжааны секторыг тодорхойлно.

Өвөрхангай аймгийн хувьд хийсэн тооцоог дараах хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 2.2. Өвөрхангай аймгийн зах зээлийн потенциалын үнэлгээ

	2013
Өвөрхангай аймгийн хүн ам	111,824
Хангайн бүсийн хүн ам	471,165
Өвөрхангай аймгийн нэг хүнд ногдох ДНБ /мянган төгрөгөөр/	3,014.9
Хангайн бүсийн нэг хүнд ногдох ДНБ /мянган төгрөгөөр/	3,368.5
Өвөрхангай аймгийн бөөний болон жижиглэн худалдааны борлуулалтын орлого /сая төгрөгөөр/	29,786.8
Хангайн бүсийн бөөний болон жижиглэн худалдааны борлуулалтын орлого /сая төгрөгөөр/	101,765.6
Зах зээлийн хамрах талбай (Trade Area Capture) /мянган хүн/	154085
Таталтын хүчин зүйл (Pull Factor)	1.38
Боломжит борлуулалт (PS) /сая төгрөг/	21617.2

Эх үүсвэр: Судлаачдын тооцоо

Тухайлбал 2011-2013 оны худалдааны хамрах талбай буюу Өвөрхангай аймгийн зүгээс орлогыг нэмэгдүүлж байгаа томоохон хүчин зүйл болох аймгаас гадны худалдан авагчдыг татаж байгаа байдлыг харахад сүүлийн жилүүдэд аймгийн үзүүлэлт тасралтгүй өсч, 2013 онд тус бүс нутагт хамгийн өндөр болсон байна.

Орон нутгийн худалдаанд оролиогчдын тоо нь тухайн орон нутгийн оршин суугч болон оршин суудаггүй аль алиных нь худалдан авалтыг тооцдог².

Өмнөхийн адилаар хэрэв орон нутгийн эрэлтийн хүчин зүйл нэгээс их бол тухайн орон нутгийн оршин суугчид зэргэлдээ нутгаас худалдан авалт хийх боломжтойг харуулдаг.

Өвөрхангай аймгийн зах зээлийн хамралтын хүрээ аймгийн өөрийн хүн амаас 1.38 дахин илүү байгаа бөгөөд нийтдээ 154 мянган үйлчлүүлэгчдийг хамруулж чадаж байна гэсэн үг.

Энэ бол юуны өмнө логистик, байршлын нөлөөний үр дүнд байгаа бөгөөд дээр хэлсэнчлэн аймгийн борлуулалтанд эдгээр хүчин зүйл чухал нөлөө үзүүлж байна.

Тооцооллоос харахад Өвөрхангай аймгийн зах зээл нь жуулчид, хөрш аймгийн хэрэглэгчид гэх зэргээр 154085 хэрэглэгчдийг татах хүчтэй нь худалдааны татах хүч нь аймгийн хүн амын тооноос их байгаа болохоор Өвөрхангай аймгийн бөөний болон жижиглэнгийн худалдаа өсөх хандлагатай.


Таталтын хүч 1.38 байгаа нь орон нутгийн борлуулалт орон нутгийн болон гаднаас ирэх хэрэглэгчдийг татснаар нэмэгдэх боломжтой гэсэн үг.

² Харин эрэлтийн таталтын хүчин зүйл нь орон нутгийн худалдаанд оролцогчдын тоог орон нутгийн хүн амд харьцуулснаар тодорхойлогддог.

$$PF_{ij} = \frac{TAC_{ij}}{POP}$$

Энд PF_{ij} нь салбар дахь орон нутгийн эрэлтийн хүчин зүйл, TAC_{ij} нь орон нутгийн худалдаанд оролцогчид, POP нь орон нутгийн хүн ам.

Зураг 2.12




Харьцуулахад 2011 онд Өмнөговийн худалдаа аймгийн хүн амаас хол давж гаднаас ирсэн хүмүүсийн борлуулалтыг ихээр олж чадсан бол, 2013 онд Өвөрхангай аймаг түүнээс илүү борлуулалтыг хийж чадсан байна.

Энэ юуны өмнө аймгийн транзит тээврийн боломж, логистикийн хөгжил, замын сүлжээ дэх байршлын давуу талын үр дүн.

Өмнөговь аймагт улсын хэмжээний томоохон уурхай хэд хэд байдаг болохоор таталтын хүчин зүйлээр Өвөрхангай аймаг түүнийг гүйцэхгүй байгаа ч гэсэн, аймгаас гаднах худалдан авагчдыг татах хүчин зүйлийн хүчээр Хангайн бүсэд 2 дугаарт орсон байна.

Өөрөөр хэлбэл, аймгаас гаднах хүмүүс Өвөрхангай аймагт ирж худалдан авалтыг ихээр хийж байгаа бөгөөд тус хүчин зүйлийн нөлөө цаашид Өвөрхангай аймагт өсөхөөр байна. Үүнд уул уурхай бус, аялал жуулчлал, транзит тээвэр хоёр их чухал болж байгаа юм.

Зураг 2.13. Таталтын хүчин зүйл /PF/ 2011-2013 он



Өнөөгийн нөхцөлд орон нутгийн бизнес, эсвэл арилжааны секторт гол төлөв орон нутгийн хүнсний дэлгүүр, өргөн хэрэглээний барааны дэлгүүр, супермаркет, зочид буудал, зоогийн газар, бусад жижиглэнгийн болон үйлчилгээний бизнес багтаж байдаг.


Эдгээрийн борлуулалтын нөхцөл нь эдийн засгийн хөгжлийн стратегийн гол анхаарах цэг, үнэн хэрэгтээ орон нутгийн зах зээлийн жижиглэн худалдааны потенциалыг тодорхойлоход ач холбогдолтой.

Худалдааны бүсийн ихэнх загваруудад тухайн зах зээлийн багтаамжийг зөвхөн хүн ам болон

хоорондын зайн функц гэж үзэж байгаа бол худалдааны бүсийн шинжилгээ нь худалдаанд оролцогчид болон эрэлтийн /pull/ хүчин зүйлийг үзэхэд цаашид аймгийн борлуулалтыг нэмэгдүүлэх боломж байгаа бөгөөд үүнийг 2011-2013 оноор тооцоход, 23.0 тэрбум төгрөгийн боломжит борлуулалтын боломж байна гэж үзэж байна.

Энэ үзүүлэлт цаашид худалдаа, логистикийн салбарыг хөгжүүлэх олон боломж байгааг харуулж байгаа бөгөөд боломжит борлуулалтын хэмжээ 2011 онд 20 тэрбум байсан бол 2013 онд 23 тэрбум болж өсч, бусад аймгуудын боломжит борлуулалт буурсан байхад, Өвөрхангай аймгийн нийт борлуулалтын боломж өссөн байна.

Зураг 2.14. Боломжит борлуулалт (PS) 2011-2013 он /сая төгрөгөөр/



Иймд худалдааны бүсийн шинжилгээг ашиглан Өвөрхангай аймгийн болон аймгаас бусад газрын арилжааны секторын эрэлтийг татаж буй байдлыг тухайн байршилд худалдаа хийж буй хэрэглэгчдийн тоогоор илэрхийлж харуулах юм.

Аймгийн боломжит борлуулалт өсөх боломжтой.

Өвөрхангай аймгийн хэмжээнд дотоодын зах зээлийн эрэлтийг хангахад хувиараа аж ахуй эрхлэгч, жижиг, дунд, том аж ахуйн нэгжүүдийн төрөлжилт, бизнесийн сайн туршлага, илүү сайн бүтээгдэхүүн, бараа, үйлчилгээг хөгжүүлж, орон нутгийн хэрэглэгчдийн хэрэглээний соёлыг дээшлүүлэх, орон нутгийн барааны эрэлтийг өсгөх, орон нутгийн бараагаа хэрэглэх хэрэглэгчдийн таашаал, үйл хөдлөлийг сэдэлжүүлэх таатай орчин бүрдэж эхлээд байна.

Хүн амын худалдан авах чадвар бага, амьжиргааны түвшин доогуур байгаа нь бизнесийн бүхий л чиглэлд хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөр оролцооны түвшинг ахиулах, хүчин зүйлсийн зардлыг бага байлгахад хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалт татах бизнесийн гол чиглэлийг тодорхойлох, орон нутгийн бизнесийн чиглэлийг дотоод зах зээлээ хангах болон экспорт руу чиглүүлэх гэсэн байдлаар эрэмбэлж, үнэт зүйл ба стратеги гаргах, түүнтэй хөрөнгө оруулалт ба санхүүжилтийг уялдуулах нь орон нутгийн зах зээлийн харьцангуй динамик байдлыг илэрхийлэх болно.

Өнөөгийн нөхцөлд орон нутгийн зах зээлийн потенциалыг нэмэгдүүлэх гол хүч нь худалдаа. Худалдаа руу чиглүүлэх бизнес нь ХАА, аялал жуулчлал, барилга, логистик.

Үүнтэй холбогдуулан аймгийн зах зээлийн давуу, сул талуудын байдал дараах байдлаар гарч байна:

Хүснэгт 2.3. Аймгийн зах зээлийн SWOT шинжилгээ

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"> Аймгийн хувьд хөдөө аж ахуй, газар тариалан зэрэг салбарт нөөц их байгаа; Тээвэр логистик, транзитын хувьд маш сайн байршилтай, дэд бүтэцтэй; Аймгийн эдийн засаг эрчимтэй өсч байна; Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалах, өвлүүлэх, ашиглах нөөцтэй; Аймгийн хойд хэсэг нь үндэсний болон дэлхийн хэмжээний аялал жуулчлалын төвтэй; Аймгийн газар зүйн бусад байршилд сул хөгжсөн тул байгаль орчин онгон дагшин хэвээр байгаа; Зөв зохион байгуулж, удирдвал шинэ бизнесийг шат дараалалтай хөгжүүлэх өрсөлдөх давуу талтай; Олон салбарт эдийн засгийн бүтэцтэй болсон байна; 	<ul style="list-style-type: none"> Хувийн хэвшлийн зохион байгуулалт, хамтын ажиллагааг илүү сайн хөгжүүлэх хэрэгтэй, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа сул; Дэд бүтэц, орчин үеийн логистикийн хөгжлийн түвшин аймгийн урд хэсгээр хөгжөөгүй байна; Салбарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө байгаа хэдий ч бүх талын ашиг сонирхолд нийцээгүй, үйл ажиллагааны хөтөлбөр, стратегийг нарийвчлан боловсруулах шаардлагаатай; Төлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтэц, тогтолцоо хэвшээгүй, санхүүжилт тодорхойгүй; Зах зээлд нийлүүлэх шинэ бүтээгдэхүүний судалгаа, брэнд бүтээгдэхүүний өртгийн сүлжээний хөгжил сул; Аяллын газарт аялагчдын тав тухтай байдлыг хангах зохистой орчин бүрдээгүй; Жижиг, дунд бизнес эрхэлж буй компаниудад санхүүжилтийн хэрэгцээ их өндөр; Түүх соёлын өвийн хамгаалалт сул; Хог хаягдал, логистикийн сүлжээний менежментийн тогтолцоо байхгүй; Бизнес инкубатор, логистикийн хүчин чадал хүрэлцээгүй, дэд бүтцийн зарим бэрхшээл; (эрчим хүч, зам)
БОЛОМЖ	ЭРСДЭЛ
<ul style="list-style-type: none"> Орон нутгийн нөөцийг зөв, үр өгөөжтэй ашиглаж, ирээдүйд баяжуулан өвлүүлэн үлдээх; Төрийн, төрийн бус байгууллага болон хувийн компаниуд хамтарч аймгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх; Зах зээлд нийлүүлэх аймгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах; Орон нутгийн нөөцийн нарийвчилсан судалгааг тодорхой хугацаанд тогтмол хийх; Мал, малын бэлчээр, газар тариалан, түүнийг дагалдан хөгжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, аяллын дамжин өнгөрөх ба аяллын газруудыг байгаа нөөцөндөө тулгуурлан цорын ганц байх шинжтэйгээр шинээр хөгжүүлэх; Жижиг дунд бизнес, өрхийн бизнес эрхэлж буй компаниуд, өрхүүдэд бизнес инкубаторыг эрдэм шинжилгээ, судалгааны байгуулагатай хамтран хэрэгжүүлэх, байнга үнэлэх гэх зэрэг зөвлөх үйлчилгээг бий болгох; 	<ul style="list-style-type: none"> Салбарын уялдаа холбоог сайжруулах, таниулан ойлгуулах, хамтран ажиллах тогтолцоог бий болгоход хугацаа шаардлагатай. Үүнийг аймгийн хөгжлийн зөвлөлөөр дамжуулан хийх шаардлагатай; Логистикийн сүлжээг шинээр хөгжүүлэхэд хугацаа шаардлагатай, их зардалтай; Шинэ бизнесийн үйлчилгээг хөгжүүлэхийн тулд орон нутгийнхнийг сургахад санхүүжилт, цаг хугацаа хэрэгтэй; Аймгийн хэмжээнд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэхэд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана; Олон улсын болон дотоодын эдийн засгийн өөрчлөмтгий бодлогын орчин орон нутгийн эдийн засгийн хөгжилд сөрөг үр нөлөөтэй;

Эх сурвалж: Судалгааны баг

2.2.2. Аймгийн зах зээлийн нөөц, боломж

ХАА-н салбар: Нөөц, үйлдвэрлэлийн хувьд салбаруудаас аймгийн хэмжээнд өнөөгийн байдлаар ХАА салбар тэргүүлж байна.

Өвөрхангай аймгийн ажил эрхлэлт ба цалингийн хувийн жинг авч үзэхэд ХАА-н ажил эрхлэлт нийт ажил эрхлэлтийн 58.8 хувийг, харин цалингийн 42.8 хувийг эзлэн эдийн засагт гол үүрэг гүйцэтгэж байна.


Өвөрхангай аймгийн ХАА-н салбар нь 100 хувь нөөцөөс (мал, газар) хамааралтай салбар бөгөөд нийт нутаг дэвсгэрийн (62.9 мян.га) 91.2 хувийг ХАА-н эдэлбэр газар, ХАА-н эдэлбэр газраас 99.1 хувийг бэлчээрийн талбай эзэлж байна.

Нийт 56.8 мян.га бэлчээрийн талбайд 2013 оны байдлаар 3486043 толгой мал бэлчээрлэж байна.

ХАА-н салбар дотроос МАА-н салбар нь аймгийн эдийн засгийн бүтцэд ихээхэн нөлөөтэй.

МАА-н салбарын зах зээлийн потенциалт ба бодит хэмжээг мал нядалгааны жинд үндэслэн тооцож үзэхэд 2009-2013 оны хооронд бодит махны үйлдвэрлэл илүү байна.

Зураг 2.12. Махны үйлдвэрлэлийн хэмжээ, 2009-2013 он/мах нядалгааны жингээр/



Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Статистикийн газар, судалгааны багийн тооцоо

2013 оны байдлаар мал үйлдвэрлэлийн потенциалт хэмжээ 26915.1 тн байгаа бол бодит хэмжээ 27792.1 тн байна.

2013 оны байдлаар потенциаласаа давсан үйлдвэрлэлтэй байна.

Сүүлийн жилүүдэд хүн амын МАА-н гаралтай бүтээгдэхүүний хэрэглээнд өөрчлөлт орж байна.

Энэ хандлага Өвөрхангай аймгийн хувьд ч илэрч байгаа юм. Тухайлбал, аймгийн махны зах зээлийн хэрэглээг жишээ харуулж байна.


Хүснэгт 2.4 Эдийн засгийн бүс болон Өвөрхангай аймгийн махны хэрэглээ /жишсэн хүнээр/

дд	Эдийн засгийн бүс, Өвөрхангай аймаг	2009		2013	
		Хүн ам /мян. хүн/	Хэрэгцээт мах / мян.тн/	Хүн ам /мян. хүн/	Хэрэгцээт мах / мян.тн/
1	Баруун бүс	383.4	43.06	372.6	39.03
2	Хангайн бүс	557.5	62.62	562.3	58.91
	Өвөрхангай аймаг	111.9	12.57	111.8	11.71
3	Төвийн бүс	448.9	50.42	468.3	49.06
4	Зүүн бүс	198.4	22.28	200.6	21.01
5	Улаанбаатар хот	1106.7	80.08	1267	94.42
	Бүгд	2694.9	258.47	2870.8	262.4

2009 онд Өвөрхангай аймгийн нийт хүн амын махны хэрэглээ 12570 тн байсан бол 2013 онд 11710 тн болж буурчээ. 4 жилийн хугацаанд жишсэн нэг хүнд ногдох махны хэрэглээ буурчээ.

2013 оны байдлаар 27792.1 тн мах үйлдвэрлэж, аймгийн хэмжээнд 11710 тн махны хэрэглээтэй байгаагаас харахад Өвөрхангай аймаг Улаанбаатар хот болон бусад аймгуудад мах экспортлох бүрэн боломжтой. Гагцхүү махны салбарыг судалгаанд тулгуурлан хөгжүүлэх хөгжлийн бодлогын стратеги тодорхойлогдох үе шатандаа явагдаж байгаа төдийгүй МАА-н гаралтай бүтээгдэхүүний логикийн хөгжлийн түвшин доогуур, ХАА-н биржийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, хүн амын махны эрэлтэнд маркетингийн хольц нөлөөлж байгааг хурдтай тусгаж, эрэлтэнд зохицсон үйл хөдлөлтэй байж чадахгүй, МАА-н гаралтай бүтээгдэхүүний салбарын орлого, ашигт байдлыг тодорхойлж мэдээлдэггүй гэх мэт олон шалтгааны улмаас энэ салбар арилжааны хэлбэртэй болж чадахгүй байна.

Зураг 2.13 Нийт малын тоо (мянгаар), хангайн бүс, /2011-2013/




Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

Үүнээс харахад, сүүлийн 2 жилийн малын хэмжээ тоогоор эрс өссөн нь харагдаж байна. Одоогийн байдлаар шинэ зах зээл гэвэл цаашид ОХУ-д чиглэсэн махны экспортын бололцоо гарч ирж байгаа боловч түүнд эхний ээлжинд үхрийн мах голлох чиглэлтэй байна.

Энэ боломжийн хувьд гэвэл аймагт үхрийн махны экспортын хувьд тийм ч өндөр боломжтой биш байна.

Одоо аймагт 144.0 мянган толгой үхрийн сүрэг байгаа нь Хөвсгөлийн 316.0 мянган үхэр, Архангайн 427.0 мянган толгойгоос ихээхэн доогуур байна. Иймээс цаашид махны экспортыг гадаадад нэмэгдүүлэхийн тулд юуны өмнө үхрийн ферм байгуулах, тоог нэмэгдүүлэх нь чухал байна.

Зураг 2.17. Үхрийн махны нөөц, хангайн бүс, /2011-2013 он/



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

Цаашид нийт малын сүргийн бүтцийг боловсронгуй болгох үүднээс үхрийн тоог нэмэх, экспортын боломжийг судлах шаардлагатай байна.

Сүүлийн жилүүдэд үхрийн тоо аймагт эрчимтэй өсч байгаа нь зөв хандлага бөгөөд фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд эхний ээлжинд үхрийн чиглэлийг дэмжих нь зүйтэй.

1980 онд Өвөрхангай аймаг 29742 га талбайд үр тариа, төмс хүнсний ногоо тариалж байсан. Газар тариалангийн үйлдвэрлэл эргэн сэргэж, 2013 оны байдлаар 2900 га тариалангийн талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан.

Цаашид эргээд 1980 оны түвшинд очих боломж байгаа үүний тулд 15950 га атаршсан талбайг эдийн засгийн эргэлтэнд оруулж түүнд зориулж логистик, тээвэр, агуулах барих чиглэлд дэмжлэг хэрэгтэй.

Монгол улсын жимс, жимсгэний зах зээлийн судалгаа, кластерийн санаачилга (2013) судалгааны үр дүнгээс харахад: баруун болон төвийн бүсэд чацарганыг түлхүү (таримал жимсгэний талбайн 70 орчим хувь) тариалах, үхэр нүд хувь, алим 15 хувь интоор, бөөрөлзгөнө 5 хувь, Алтайн өвөр говийн бүс нутагт чацаргана хувь, алим хувь, яст жимс хувь, бусад жимс хувь байхаар тариалах боломжтой гэж тодорхойлсон.

Чацарганыг дагалдаж үрт жимс, жимсгэнэ голлоно. Тухайлбал, алим, үхэр нүд, тошлой, интоор, бөөрөлзгөнө, гүзээлзгэний таримлыг түлхүү тариалах боломж Өвөрхангай аймгийн Хархорин суманд байна.

Цаашид Хархорин сумыг улсын хэмжээний чацарганы үйлдвэрлэлийн төв болгох үүднээс юуны түрүүнд нийлүүлэлт, борлуулалтын сүлжээ үүсгэх, хөргөлттэй агуулах, хадгалах, тээвэрлэх техник хэрэгслийн хөрөнгө оруулалтыг дэмжих шаардлагатай.

Үрсэлгээний чанар, сортын бодлого, бүтээгдэхүүний стандарт (компаний ба улсын)-ыг хөгжүүлж, мөрдүүлэх хэрэгтэй байна.

Аялал жуулчлал

Өвөрхангай аймаг нь говь, тал хээр, хангай бүс хосолсон байгалийн үзэсгэлэнт, дурсгалт газрууд арвин ихтэй газар нутаг юм.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгал жагсаалтанд Өвөрхангай аймагт улсын хамгаалалтанд 9, аймгийн хамгаалалтанд 26 үл хөдлөх дурсгалт газрууд хамрагдсан.

Улсын хамгаалалтанд байх түүх, соёлын дурсгал

· Баруунбаян-Улаан сумын Андай сайр, Шанд гол, Таацын гол, Тамал голын палеонтологийн дурсгалт газрууд

- Бат-Өлзий сумын Хойд агуйт гэдэг газар орших Төвхөн хийд
- Гучин-Ус сумын Өөшийн нуруу /Гучингийн нуруу/, Хөөвөрийн палеонтологийн дурсгал газар
- Уянга сумын Онгийн голын цогцолбор дурсгал
- Хайрхандулаан сумын Хөгшинтээл ууланд орших Хубилайн цэргийн цайзны туурь
- Хархорин сумын Мойлтын ам гэдэг газар орших хуучин чулуун зэвсгийн үеийн бууц
- Хархорин сумын төвд орших Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурь, түүний орчим дахь 2 ширхэг чулуун яст мэлхий
- Хархорин сумын төвд орших Эрдэнэ зуу хийд
- Хархорин сумын төвд орших Занабазарын эх Ханджамцын суварга

Аймгийн хамгаалалтанд байх түүх, соёлын дурсгал

- Арвайхээр сумын төвд орших Буга согоотын хадны зураг
- Баруунбаян-Улаан сумын Хүнхэрээ гэдэг газар орших Шаазан толгойн туурь
- Баруунбаян-Улаан сумын Таримлын өвөлжөөний урд орших хүн чулуу хөшөө
- Баруунбаян-Улаан сумын Өшгөгийн нуруунд орших Хярын бумбат, Барчин тээгийн хадны зургууд

- Бат-Өлзий сумын Тэмээн чулууны аманд орших буган чулуун хөшөө булшууд
- Бат-Өлзий сумын Өндөр хясаа гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Бат-Өлзий сумын Өвөр агуйт гэдэг газар орших хиргисүүр
- Бат-Өлзий сумын Ар агуйтын хөшөөн хонхорт орших хөшөө
- Баян-Өндөр сумын Зүйлийн хөндийд орших Буурлын хүн чулуун хөшөө
- Богд сумын Тэвш ууланд орших хадны зураг
- Богд сумын нутагт орших Илжгэн чихт хааны хэрэм
- Богд сумын Арц богд уулын зүүн үзүүр Мухар булаг гэдэг газар орших чулуун зэвсгийн суурин
- Нарийнтээл сумын нутагт орших Ламын гэгээний суварга
- Нарийнтээл сумын нутагт Ариат гэдэг газар орших эрдэмтэн Цэвэлваанчигдоржийн суварга
- Уянга сумын Хадан хошуун гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Уянга сумын нутагт орших Мааньтын хөшөө
- Хархорин сумын нутагт орших Шанхын хийдийн дуганууд

- Хархорин сумын урд Мэлхий толгой дээр орших барилгын туурь, чулуун яст мэлхий
- Хархорин сумын урд Мэлхий толгойн бэлд орших эрхтэн чулуун хөшөө
- Хархорин сумын Бага хүрээ гэдэг газар орших дутуу хийсэн чулуун яст мэлхий
- Хархорин сумын нутагт орших Их элстийн дэнжийн хөшөө
- Хархорин сумын нутагт Саран голын баруун эрэгт орших Хар чулууны хүн чулуун хөшөө
- Хархорин сумын Хөшөөн дэнж, Саран голын эрэгт орших хүн чулуун хөшөө
- Хархорин сумын Зараа толгой гэдэг газар орших хадны зураг, бичээс
- Хархорин сумын Гүмбийн дэнжид орших буган чулуу хөшөө
- Хужирт сумын Шунхлай ууланд орших дөрвөлжин булшнууд

Өвөрхангай аймаг Монгол улсын хэмжээнд төдийгүй дэлхийд түүхийн дурсгалтай, үзэсгэлэнт газраар тэргүүлэх байршлын нэг байгаа. Үүнд Хархорин, Орхоны хөндий болон бусад газрууд зүй ёсоор орж байгаа бөгөөд тус салбарыг хөгжүүлэх нөөц бол нилээд их байгаа нь тус судалгаанаас гарч ирж байна.

Аялал жуулчлалын салбарын онолог гэвэл бие биенийгээ дэмжин ажиллах кластер (уоги) болгон хөгжүүлэх санаачилгыг хэрэгжүүлэх нь эдийн засгийн бодлогын гол хэрэгсэл болж байна.

Учир нь эдгээр салбар ажиллах хүчээ чадавхжуулж чадвал нөөцөнд түшиглэсэн салбараас орон нутгийн хийгээд аялал жуулчлалын кластер болон хөгжүүлэх боломж харагдаж байна.

Аялал жуулчлалын кластерт газар зүйн хувьд ойролцоо байршдаг үзэсгэлэнт газар, үйлчилгээний багц, компаниудын сүлжээ, зочид буудал, хоол, худалдаа, амралтын газар болон соёлын үйлчилгээ бүгд орж байгаа.

Мөн сүүлийн үед үүнд хөлсний тээвэр, түрээсийн унаа (машин, мотоцикль, дугуй) зэрэг ордог болсон бөгөөд жуулчдыг олон газраар зэрэг орох боломжийг улам нэмэгдүүлж байна гэсэн үг.

Сүүлийн жилүүдэд аялал жуулчлал, ХАА, барилга зэрэг салбартай зэрэгцэн орлого оруулах чухал салбар гэдгийг дэлхий даяар хүлээн зөвшөөрч түүнийг хөгжүүлэх олон шинэ санаа, инноваци гарч ирж байна. Аялал жуулчлал бусад салбаруудад шууд нөлөөлж ажил эрхлэлт, эдийн засгийн хөгжлийг түргэсгэдэгээс гадна шууд бусаар нийтлээ бүс нутгийн хөгжилд ихээхэн хувь оруулдаг салбараар тооцогддог.

Аялал жуулчлалын кластерыг үүсгэхэд эхний ээлжинд:

- Түүхэн дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газрууд;
- Наадам, уламжлалт баярын арга хэмжээ;
- Аялал жуулчлалын дэд бүтэц (зам) ордог; түүнд дэмжлэг үзүүлэх
- Боловсон хүчин;
- Зочид буудал;
- Хоолны газар, цэнгээний газар;
- Эмчилгээ;
- Худалдаа болон үйлчилгээний газар;
- Олон төрлийн аялал жуулчлалын төрөлд зориулсан мэргэжлийн үйлчилгээ;
- Спортын болон соёлын арга хэмжээ ордог.

Эдгээр кластер (уогиолбор)-ыг бүрдүүлэхэд хувийн хэвшлийн компаниуд идэвхтэй оролцох боловч зохион байгуулалт, нэгдсэн удирдлага, зохицуулалт болон мэдээллийн түгээлтийг сайжруулах нь зайлшгүй төрийн оролцоо чухал.

Монгол улсын хэмжээнд аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрүүд байдаг ч гэсэн төдийлөн үр дүн өгөхгүй байгаа нь кластерын шинж чанартай уоги үйлчилгээг бүрдүүлж чадахгүйтэй холбоотой байж болно.

Одоогийн байдлаар Өвөрхангай аймаг улсын хэмжээний аялал жуулчлалын төв болсон байгаа ч гэсэн тус салбарыг улам их хөгжүүлж, олон төрлийн шинэ орлого оруулах нөөц боломж байна. Үүний тулд аялал жуулчлалын шууд ба шууд бус дагалдах үйлчилгээг хөгжүүлэх шаардлагатай.

Аймгийн хувьд аялал жуулчлалын кластерыг иж бүрнээр нь улсын хэмжээнд анхдагч болж бүрдүүлэх бололцоотой.

Дээрх жишээнээс харахад жуулчдыг татах дараагийн нөөц бололцоо аймагт байна.

1. Боловсронгуй шоппинг (худалдаа үйлчилгээ), Хархорин, Арвайхээр
2. Жуулчдад зориулсан богино хугацааны эмчилгээ үйлчилгээний газар (массаж, эмнэлгийн үйлчилгээ) Хархорин, Арвайхээр
3. Мэргэжлийн болон техникийн аялал жуулчлалын боловсон хүчинг бэлтгэх байгууллага;
4. Жуулчдад зориулсан тээврийн үйлчилгээний төрөл, чанарыг дээшлүүлэх, нэмэгдүүлэх (жишээ нь түрээсийн уулын дугуй, машин гм) Арвайхээр, Хархорин;
5. Музейн үзмэрийг соёлын арга хэмжээтэй тогтмол хослуулах Хархорин, Арвайхээр;
6. Жуулчдад зориулсан томоохон спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах Хархорин, Арвайхээр (жишээ нь уулын дугуйн бартаат уралдааны тэмцээн, завиар уралдах рафтинг гм);

Дээрээс нь үйлчилгээний чиглэлээр дутаж байгаа нэг зүйл гэвэл мэдээлэл байна.

Аймгийн үзэсгэлэнт газруудын танилцуулга, маршруттын нэгдсэн танилцуулга англи хэл дээр, эсвэл орос хэл дээр байхгүй байна. Монгол хэл дээр вэбсайт, сошиал медиаг ашигласан зарим хуудас байгаа ч хугацааны хувьд байнга шинэчлэл хийгдэггүй, шинэ мэдээ, мэдээлэл ховор байна,

англи хэл дээр ч бүүр олдохгүй байна. Хэдийгээр үүнийг компаниуд тус тусдаа хийж байгаа ч гэсэн үүнийг нэгдсэн байдлаар нэгтгэж портал болгох нь зайлшгүй чухал байгаа.

Өмнө нь гарч байсан судалгаанаас гадаадын жуулчид, мөн дотоодын жуулчид ихэвчлэн Хархоринд очиж, аймгийн хойд хэсгээр их явдаг боловч урьд хэсэг рүү болон Арвайхээр сумаар дайрч өнгөрөх сонирхол бага байдаг. Гэтэл жуулчдыг аймгийн нутагт 1-2 хоногоор илүү байлгаж чадвал, тэр хэмжээгээр аймгийн аялал жуулчлалын орлого нэмэгдэнэ. Иймээс Хархорин суманд ирсэн жуулчдыг цаашлаад Арвайхээр сум руу татах арга хэмжээ авах нь чухал байна.


Жуулчдыг татах үзвэр үйлчилгээний нэг төрөл болох музейн хувьд Өвөрхангай аймагт нөөц боломж байна. Хархорин суманд шинэ музейг Японы олон улсын хамтын ажиллагааны тусламжтайгаар нээн ажиллуулснаараа музей үзэгчдийн тоогоор бүсдээ тэргүүлж байна.

Цаашид аяллын зорин очих газарт жуулчдыг татах өөр бусад үйлчилгээний төрлийг үүний нэгэн адил нэмэгдүүлэх боломжтой.

Музей, түүхэн дурсгалт газар маш ихтэй, ийм үзүүлэлтээр Архангай, Булган, Хөвсгөл аймгуудаас хол давсан ч гэсэн сүүлийн жилүүдэд Баянхонгор аймгаас үзмэрийн тоогоор хоцорч эхэлсэн. Жуулчдыг татахын тулд үзмэрийн тоог байнга нэмж, шинэ үзвэрийг санал болгох, шинэ музейг нээж ажиллуулах, сумын соёлын төвийн үйл ажиллагааг идэвхжүүлэх нь нэн чухал байна.

Дараагийн том ашиглаагүй нөөц бол мэргэжлийн урлагийн тоглолт гэж үзэж байна.

Зураг 2.15. Урлагийн тоглолтын үзэгчдийн тоо



Эх сурвалж: ҮСХ, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

Өвөрхангай аймагт урлагийн тоглолтын үзэгчдийн тоо сүүлийн үед буурч байгаа бөгөөд Архангай, Баянхонгор аймгаас хэт доогуур байгаа нь тодорхой байна.

Аялал жуулчлалын хувьд жуулчдад иж бүрэн үйлчилгээ үзүүлж, орлого олох ажил дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, жуулчид Өвөрхангай аймагт ирж музей, сүм, үзэсгэлэнт газруудыг үзэхээс өөр төрлийн үйлчилгээ, тухайлбал, эдгээр газартай холбоотой тоглолт, жүжиг, концерт, мөн түр үзэсгэлэн, төрөл бүрийн эвент, спортын арга хэмжээг цогцоор нь зохион байгуулбал орлого татах боломжтой.

Ялангуяа наадмын дараах үед (7 дугаар сарын дундуур) жуулчид олноор Улаанбаатар хотоос ирэх үед аймгийн соёлын байгууллагын хүчээр Хархорин, Хужиртаас Арвайхээр руу татах, улмаар төвлөрүүлж Монголын уламжлалт урлагийн тоглолтыг тур оператор компаниудтай урьдчилан тохиролзон тогтмол хэрэгжүүлэх бүрэн бололцоотой.

Мөн Эрдэнэзуу музейг түшиглэн үдэш орой, мөн уламжлалт урлагийн тоглолт, концерт зохион байгуулах нь орчин үеийн аялал жуулчлалын хөгжлийн хандлагатай нийцсэн, аль аль салбарын орлогыг нэмэгдүүлэх боломжийг нээнэ.

Зураг 2.16. Түүхэн дурсгалт газрын дэргэдэх уламжлалт болон сонгодог урлагийн тоглолт, концерт (Egunem, ОХУ)



Аймгийн аялал жуулчлалын үзэсгэлэнт газруудын тухай вэб сайт, мэдээлэл (монгол, англи, орос, хятад, япон хэлээр), хэвлэлийн реклам гэх зэрэг мэдээ, мэдээлэл, баримт их дутагдаж байна.

Хэдийгээр хувийн компаниуд өөрийн аялалын талаар реклам, зар түгээж байгаа ч гэсэн жуулчдын сэтгэл ханамж, аяллын шинэ, шинэ бүтээгдэхүүн, зорин очих газрын талаар илүү сайн сурталчилгаа явуулж, шинэ шинэ маршрутыг нээх хэрэгтэй байна.

Үүнийг системтэй зохион байгуулах, аялал жуулчлалын тур компаниудтай хамтран ажиллах нь цаашид аялал жуулчлалын өсөлтийг бий болгох алтан боломж байна. Энэ бол аялал жуулчлалын кластерын чухал хэсэг болно.

Аймгийн аялал жуулчлалын өөр нэг том нөөц бол нутгийн иргэд. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (НИТАЖ)-ыг хөгжүүлэх нь нүүдлийн ахуй соёлоо хадгалан үлдэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, зохион байгуулалттай эвент хөгжүүлснээрээ жуулчдын урсгалыг татах боломжтой.

Өвөрхангай аймгийн аялал жуулчлалыг голлон хөгжүүлэх сумдад нутгийн иргэдийг бэлтгэж эхлэх нь аялал жуулчлалын зах зээлийн том сорилт. Нутгийн иргэд тур оператор компаниудтай хоршин ажилласнаараа орон нутагтаа үнэт зүйл бүтээх бололцоотой.

Их хаадын эртний нийслэл Хархоринг үзэх, тэнд соёлын тоглолт, эртний Монгол дуурь бүжгийг сонирхож, дараа нь Арвайхээрт очиж аймгийн музейд шинэ үзвэр, урлагийн тоглолт, зургийн галерей зэргийг үзэж, Их хаадын морин уралдаан, эртний хувцастай Монгол бөхийн барилдаан зэргийг үзэх боломжийг нэгдсэн байдлаар зохион байгуулвал үр дүн сайтай, жуулчдын тоо ихтэй болно.

Мөн Их хаадын үеийн монгол иэргийн парад, Цагаан, Хар сүлдийг Хархорин сумын Эрдэнэ зууд залах ёслол зэргийг зохион байгуулж болох бололцоотой.

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар

Барилгын салбар Өвөрхангай аймагт хөгжиж ирсэн урт түүхтэй. 1959 оны 4 дүгээр сарын 20-нд Хархоринны сангийн аж ахуйн төвд Барилга угсралтын анги гэсэн анхны мэргэжлийн байгууллага байгуулагдаж, 1964 оны 4 дүгээр сард Арвайхээр суманд төвлөрч, Барилга монтажийн контор болж өргөжснөөр Өвөрхангай аймагт барилгын салбарын анхны алхам тавигдсан.

1979 онд ОХУ (тэр үеийн ЗСБНХУ)-тай хамтран жилд 5000 м³ төмөр бетон, 2000 м³ товарын бетон, 7000 м² хаалга цонх болон барилгын модон эдлэл үйлдвэрлэх иж бүрэн үйлдвэр, 1985 онд БНБАУ-ын техник эдийн засаг, мэргэжилтний оролцоотойгоор жилдээ 16.0 сая тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай ханын материалын үйлдвэр барьж ашиглалтанд оруулсан.

Мөн 1980-аад оны эхээр Герман улсын тоног төхөөрөмжөөр тоногдсон хүрмэн блокны цех байгуулснаар барилгын салбарт томоохон үсрэлт байсан.

Өнөөгийн барилгажилт, орон сууцны барилга ид хөгжиж байгаа өнөө үед Өвөрхангай аймаг нь барилгын материалын нөөц ихтэй. Үүнд тоосго, цемент, керамзит блок, бетоны үйлдвэр хөгжих боломжтой.

Аймгийн хэмжээнд цаашид эдгээр түүхийн эдийн нөөцийг тулгуурлан барилгын материалын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх боломж, нөөц их байгааг харгалзан бизнесийн орчинг сайжруулж, зөвшөөрөл, лиценз олгох ажлыг боловсронгуй болгох шаардлагатай.

Тус салбарт 2010 онд 10 компани 1082 хүнтэй ажиллаж байсан бол 2013 онд барилгын салбарт 29 компани 2043 хүнтэй ажиллаж, аймгийн хэмжээнд ХАА, худалдааны салбарын дараах тэргүүлэх салбар болж байна.

Хүснэгт 2.5 Өвөрхангай аймгийн барилгын материалын ЖДҮ хөгжүүлэхэд шаардагдах эрдэс, түүхий эдийн төрөлжсөн судалгаа

дд	Сумын нэр	Ордын зориулалт, нэр	Нөөц хэмжээ А+В С1+С2			Байгуулах ЖДҮ-ийн нэр	Үйлдвэрлэж болох бүтээгдэхүүний нэр, төрөл
			Үйлдвэр	Нөөц	Бүгд		
1	Зүүнбаян-Улаан	Өвдөг худгийн тоосгоны шавар	405+671	108+311	2395	Тоосгоны үйлдвэр	Ердийн тоосго, вааран черепиц
2	Хархорин	Тоосгоны шавар	753+1133	3148+599	5631.1	Тоосгоны үйлдвэр	Ердийн тоосго, вааран черепиц
3	Хужирт	Тоосгоны шавар		-370	370	Тоосгоны үйлдвэр	Ердийн тоосго, вааран черепиц
4	Тарагт	Онгийн голын элс хайрга Дөлгөөний шохойн чулуу	143+380	1418-	1941	Олборлох карьер Шохойн чулууны карьер	Бетон дүүргэгч, Бетон эдлэл Шохой, хуурай хольц, эрдсийн нунтаг
5	Нарийнтээл	Таацдын голын хүрмэн чулуу	101		101	Олборлох карьер	Цементийн нэмэлт, хөнгөн дүүргэгч, хүрмэн бетон блок
6	Богд	Хүрмэн чулуу	-259	436+296	991	Олборлох карьер	Цементийн нэмэлт, хөнгөн дүүргэгч хүрмэн бетон блок
7	Хархорин	Саарал боржин чулуу		3500	3500	Олборлох цех	Өнгөлгөөний чулуу

Эх сурвалж: ЭЗХЯам

Хүснэгт 2.6. Өвөрхангай аймгийн ААН-ын тоо, ажиллагчдын тоо, салбараар, /2005-2013 он/

Салбарын ангилал	2010		2011		2012		2013	
	ААН	Ажилчид	ААН	Ажилчид	ААН	Ажилчид	ААН	Ажилчид
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	48	30702	55	30332	63	30442	78	29350
Уул уурхай, олборлох үйлдвэр	6	1133	35	1059	41	1078	41	948
Боловсруулах үйлдвэр	56	594	58	694	86	699	89	980
Барилга	10	1082	22	1273	22	1450	29	2043
Бөөний болон жижиглэн худалдаа	161	4449	153	4130	183	4305	230	4639
Зочид буудал, зоогийн газар	21	1021	24	1087	22	1052	21	1214
Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	15	1097	19	1110	24	1127	27	1094
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	10	352	13	374	10	396	13	434
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	17	56	30	46	37	301	43	111
Боловсролын салбарын үйл ажиллагаа	70	2249	75	2466	71	2409	70	2612
Нийт дүн	694	47384	735	792	792	885	49865	

Эх сурвалж: YCX, www.1212.mn цахим мэдээллийн хуудас

Сүүлийн жилүүдэд аймгийн бүтээн байгуулалт ихээхэн өргөжиж 2013 оны байдлаар нийт 59221.9 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийгдсэний 24136.6 сая төгрөг буюу 40.7 хувийг барилга угсралт, 2109.6 сая төгрөг буюу 3.6 хувийг их засвар, 32975.6 сая төгрөг буюу 55.7 хувийг авто зам засвар, арчлалтын ажил тус тус эзэлж байна. Орон нутагт нийт 29 барилгын аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байгаагаас тогмтол үйл ажиллагаа явуулдаг 20 байгууллага байна. Орон нутгийн байгууллагууд 2013 онд 7328.5 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил, 1926.8 сая төгрөгийн авто зам засвар, арчлалтын ажил хийж гүйцэтгэсэн нь нийт төсвийн 15.6 хувийг эзэлж байна.

Дэд бүтцийн ажлаас гадна барилгын салбарт нөлөөлөх нь юуны өмнө зах зээлийн эрэлт учраас, цаашид аж ахуй эрхлэгчдийн тоо хангалттай байхаас гадна аймгийн зах зээлийн эрэлтийг хангалттай түвшинд байлгах шаардлагатай. Хэрвээ аймгийн аж ахуйн нэгжүүд дотоодын зах зээлийн эрэлтийг хангах түвшинд хүрээгүй бол бусад газраас хөрөнгө оруулагчдыг татах болно. Тиймээс цаашид барилгын томоохон төслүүдийн үйл ажиллагаа, тухайлбал онгоцны буудал, томоохон худалдааны төв (молл), дэлгүүр, аж үйлдвэрийн төв зэргийг санаачлан барилгын салбарт ажлын байр бий болгох шаардлагатай.

Өвөрхангай аймаг нь барилгын материалын ЖДҮ-ийг хөгжүүлэхэд шаардлагатай түүхий эдийн нөөцтэй бөгөөд тэдгээр нөөцийг ашиглаад ердийн тоосго, вааран черепиц, бетон дүүргэгч, бетон эдлэл, шохой, цементийн нэмэлт, хүрмэн бетон блок, өнгөлгөөний чулуу гэх мэт барилгын материал үйлдвэрлэх боломжтой. 2013 оны байдлаар 2267.4 мянган тоосгийг 802.8 сая төгрөгөөр, 735.4 мянган блокыг 777.0 сая төгрөгөөр үйлдвэрлэжээ.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас хийсэн судалгаагаар Өвөрхангай аймагт 13.3 тэрбум төгрөгөөр барилгын материалын үйлдвэрийг шинээр барих шаардлагатай гэж үзжээ.

Хүснэгт 2.7. Өвөрхангай аймагт барилгын материалын шинээр барих шаардлагатай үйлдвэрийн жагсаалт, санхүүжилт

дд	Үйлдвэрийн нэр	Хүчин чадал	Барих хугацаа	Ашиглах орд	Шаардагдах хөрөнгө оруулалт /сая төгрөг/	Санхүүжүүлэх эх үүсвэр
1	Төмөр бетон эдлэлийн үйлдвэр	15000 м³	2014-2015	Онгийн голын элс хайрганы орд		Хувийн хөрөнгө оруулалт
2	MNS 0831:2001 стандартын Сийрмэг /блок/ бетоны үйлдвэр	5000 м³	2016	Онгийн голын орд	2400.00	
3	Өнгөлгөөний чулууны үйлдвэр	10000м³	2016	Хархорины саарал боржин	3800.00	
4	Эрдэс хөвөн	30000м³	2016	Орхоны базальт	2600.00	

Эх сурвалж: ЭЗХЯам

Уул уурхай салбар

Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт 2006 оны байдлаар ашигт малтмалын 33 төрлийн 210 гаруй орд, илрэл тогтоогджээ. Ашигт малтмал тус бүрээр авч үзвэл:

Үнэт металаас: алтны 23 илрэл, 41 орд, зэсийн 29 илрэл, 2 орд, молибдений 5 илрэл, хар тугалганы 5 илрэл, 1 орд, цагаан тугалганы 7 илрэл, гянтболдын 18 илрэл, бериллийн 1 илрэл, висцутын 1 илрэл, мөнгөн усны 1 илрэл, мишьякийн 2 илрэл, титаны 1 илрэл, мангааны 1 илрэл, 7 орд, төмрийн 17 илрэл 6 орд, газрын ховор элементийн 2 илрэл, эрдэнийн чулууны 17 илрэл, 5 орд, бал чулууны 10 илрэл, гөлтгөний 1 илрэл, марганцын 2 илрэл, оптекийн түүхий эдийн 8 илрэл, 1 орд, гялтгануурын 3 илрэл, эрдсийн будгийн 4 илрэл, хайлуур жоншны 7 илрэл, 1 орд, давсны 2 илрэл, 1 орд, шатах ашигт малтмалын 10 илрэл, 3 орд, шатдаг занарын 1 орд тус тус байна.

Аймгийн хэмжээнд Уянга, Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Төгрөг, Хайрхандулаан, Хужирт, Нарийнтээл сумдад нийт 42 ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл олгосноос алтны 27, нүүрсний 1, жоншны 1, гянтболдын 2 тусгай зөвшөөрөл байна. Эдгээр 31 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг улс орноор ангилж үзвэл "Гацуурт" ХХК, "Алтандорнод Монгол" ХХК зэрэг үндэсний 26 компани, 100 хувийн хөрөнгө оруулалттай гадаадын 1 компани, хамтарсан хөрөнгө оруулалттай 4 компани байна.

Өвөрхангай аймаг нь байгалийн эрдэс баялаг ихтэй, түүний дотроос алтны нөөцөөр багагүй аймгийн тоонд багтдаг. Олборлоход хялбар, зардал бага, хөнгөхөн борлуулах боломжтой зэрэг давуу талтай алтны шороон ордыг компани, нөхөрлөл, нинжа хэлбэрээр олон жилийн турш олборлосон нь байгаль орчинд сөрөг нөлөө ихээр үзүүлж, олон газар нөхөн сэргээгдэлгүй эвдэрч

үлдсэн.

Өвөрхангай аймаг нь алтны шороон ордын нөөц ихтэй нутгийн нэг бөгөөд 2013 оны эцсээр Улсын эрдэс баялгийн нөөцийн санд шороон ордын 1200 орчим кг алтны нөөц бүртгэгдсэн урьдчилсан мэдээ байдаг.

Уул уурхайн салбар бол аймгийн хувьд урт хугацаандаа илүү нарийвчилсан судалгаа, шинжилгээний үндсэн дээр олон нийтийн хяналт, оролцоог хангахуйцаар хамтын ажиллагааны институцийг хөгжүүлэх салбар юм.

Алт олборлолтын зохисгүй байдлыг дахин давтагдуулахгүйн тулд аймаг, сум орон нутгийн захиргаанаас уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчинг сайн судалж, нутгийн хөгжилд хувь нэмэр оруулсан иргэдийн амьдралд дэмжлэг болсон, байгаль орчинд хал багатай уул уурхайг хөгжүүлэх, төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, тооцоонд суурилж хийх нь чухал юм.

Эдийн засгийн хөгжлийн дунд урт хугацааны төлөвлөлтөнд дараах ордуудад геологийн нарийвчилсан хайгуулаар нөөцийг шинэчилэн тогтоох шаардлагатай.

- Нөөц өсөх ирээдүйтэй Таашийн голын илрэл алт /660.0 кг/-ыг нарийвчлан судлах;
- Даргуйтын сархиагийн алт /836.8 кг/, хар тугалга /14914.0 тн/, цайр /8273.9 тн/, мөнгө /48785.2 тн/-ийг геологийн нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжийг судлах, хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах;

- Нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжтой Улаан толгойн илрэл /зэс 726845 тн, молибден 13219 тн/-ийг геологийн нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжийг судлах, хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах;

- Р-гийн ихээхэн нөөцтэй Хүрэн өндөрийн /4375460 тн/, Цагаан Овоотын 19557 тн/ ордыг геологийн нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжийг судлах, хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах;

- Нөөц өсөх ирээдүйтэй Зүүнбулагийн шатдаг занарын орд /130 сая тн/-ыг нарийвчлан судлуулах;

Аймгийн эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулахуйц харуулагатай уул уурхайг хөгжүүлэхэд дараах асуудлуудыг анхаарх шаардлагатай. Үүнд:

1. Баянтээгийн ордын ашиглалтыг эрчимжүүлэх дэд бүтцийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;
2. Хэдэн оноос ямар ордыг ашиглуулах, ямар нэр төрлийн бүтээгдэхүүн үйдвэрлүүлэх, орон нутгийн төсөвт оруулах хувь нэмрийн төсөөллийг дунд хугацаанд гаргаж, богино хугацаанд тодотголыг хийж байх;
3. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх талаар төрийн захиргааны байгууллага, хөрөнгө оруулагчидтай жил бүр хамтарсан семинар бусад хэлбэрийн ажлыг зохион байгуулах;
4. Уурхайн хаалтын төлөвлөгөөг хөрөнгө оруулагчдаас авч хэрэгжилтийг дүгнэж хэвших;
5. Ажиллах хүчний эхний ээлжинд орон нутгаас бэлтгэж, уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдад гэрээгээр ажлын байраар хангах;
6. Улсын болон бүс нутгийн хатуу хучилттай авто зам хүртэл хийх уурхайн тээврийн замыг хатуу хучилттай болгох;
7. Уурхайн эрчим хүчний дэд өртөөнөөс ойролцоо амьдрах нутгийн иргэдийг хангах асуудлыг хамтран шийдвэрлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Аймгийн хөгжлийн гол түлхүүр салбаруудын нэг нь Баянтээгийн нүүрсний уурхай болох бололцоотой байгаа. Баянтээгийн нүүрсний орд нь Өвөрхангай аймгийн баруун өмнө хэсэгт Нарийнтээл сумын нутагт орших бөгөөд аймгийн төвөөс 130 км, Архангай аймгаас 467 км, Баянхонгор аймгаас 100 км, Улаанбаатар хотоос 560 км зайд оршдог бөгөөд 1962 онд жилд 25.0 мянган тн нүүрс олборлох хүчин чадлаар байгуулагдаж, 1978 онд гүйцэтгэсэн нарийвчилсан хайгуулаар нөөцийг үйлдвэрлэлийн зэрэгт шилжүүлэн 29.6 сая тн-ын нөөцтэй гэж тогтоосон. Байгуулагдсан цагаас хойш /50 жилийн хугацаанд/ 5961.48 мян.м³ хөрс хуулж, 4861.7 мянган тн нүүрс олборлон борлуулаад байна.

Баянтээгийн нүүрсний уурхай MV-00367 тоот тусгай зөвшөөрлөөр 584 гектар талбайд нүүрс олборлох үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд цаашид өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээг хангахын тулд төрөөс уул уурхайн томоохон орд газруудыг түшиглэн 40 мвт-ын дулааны цахилгаан станц барих төлөвлөлт бий. Мөн Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн дунд хүчин чадлын нүүрсний хийн станц барьж байгуулах төлөвлөгөө ч гарсан байна.

Худалдаа үйлчилгээ, тээвэр логистикийн салбар


Баянтээгийн нүүрсний уурхайг ашиглах боломжийг нэмэгдүүлэхийн тулд юуны өмнө шинэ зах зээлд буюу БНХАУ уруу чиглэсэн дэд бүтцийн хөгжил нэн чухал байна. Хэрэв Арвайхээр-Шивээхүрэнгийн засмал замын асуудал шийдэгдэх бол, Нарийнтээл-Арвайхээр-Шивээхүрэнгийн тээвэрлэлтийн шинэ боломж нээгдэх болно.

Авто замын хувьд аймгийн баруун, зүүн, төв, хойд хэсэгт хүртээмж сайтай байгаа ч гэсэн цаашид Монгол улсын гол экспортын зах зээл болох БНХАУ буюу урд зах зээл рүү одоогийн байдлаар гарч дутмаг байна. Тиймээс аймгийн урд хэсгийн сумдад авто замаар очих, Өмнөговь

аймгийн зах зээлд гарахад тодорхой хүндрэл учирч байна.

Цаашид Өмнөговь аймагт бүтээн байгуулалт, ялангуяа Оюутолгой үйлдвэрийн үйл ажиллагаа ихээхэн идэвхжих тул Өмнөговь аймгийн зах зээл, цаашилбал БНХАУ-ын зах зээл рүү гарах гарц, засмал замыг тавих шаардлага тулгарч байна.

Өөрөөр хэлбэл босоо тэнхлэгийн Хархорин - Хужирт - Арвайхээр чиглэлийн 54 км замыг цаашид Арвайхээр - Гучин-Ус - Шивээхүрэн - улсын хил чиглэлийн 485 км замыг бий болгох нь аймгийн хөгжлийн гол чиглэл болно гэж үзэж байгаа.



Зураг 2.18. Шинээр ээхний ээлжинд тавих хөгжлийн онцгой ач холбогдолтой зам, Арвайхээр-Шивээхүрэн

Цаашид аймгийн нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах үүднээс транзит тээвэр, логистикийг хөгжүүлэх нь нэн чухал.

Монгол улсын хувьд одоо нийт худалдааны нилээд их хувийг Замын-Үүд боомт, экспортын томоохон хувийг Гашуун сухайт боомтоор хийж байгаа ч гэсэн ойрын жилүүдэд Шивээхүрэнгийн боомтын ач холбогдол нилээд өсөх хандлагатай байна.

Иймд Өвөрхангай аймгийн хувьд БНХАУ-ын зах зээлд Шивээхүрэнгийн боомтоор гарах гарцтай болох нь экспортын боломжийг нэмэгдүүлэх нэг чухал эх үүсвэр. Гурвантэс-Шивээхүрэнгийн 45 км зам ашиглалтанд орсон байгаа учир одоо аймгаас Өмнөговь аймаг руу ойртох замыг ойрын жилүүдэд эхлүүлэх нь нэн чухал байна.

Тус замыг ашиглалтанд оруулснаар аймгийг дайрсан транзит тээврийн хэмжээ үлэмж нэмэгдэх боломжтой.

Одоогийн байдлаар Шивээхүрэнгийн боомт улсад Замын-Үүд, Гашуун сухайт, Алтанбулагийн боомт, Буянт-Ухаагийн дараа урсгалын хэмжээгээр орох чухал боомт болох бөгөөд жилд тус боомтоор 90 мянган хүн зорчиж, импортлогдож байгаа бараа бүтээгдэхүүнд хүнс, химийн бодис, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, барилгын материал, уул уурхайн техник тоног төхөөрөмж зонхилж байгаа бол экспортлогдож байгаа бараа бүтээгдэхүүнд мал амьтны гаралтай түүхий эд, ашигт малтмал, нүүрс зонхилж байна. Одоогоор “Чинхуа-Мак” ХХК, “Мак” ХХК, “South Gobi Sands” ХХК-удын уурхайгаас нүүрс тээвэрлэж, тус боомтоор БНХАУруу экспортлож байна.

Цаашид Өвөрхангай аймаг барилгын материалын транзит цэг болох, мөн үүнд олон улсын аялал жуулчлалын маршрут, логистикийг нэмэх хэрэгтэй.


Одоогийн байдлаар олон улсын болон дотоодын жуулчид Өвөрхангай аймагт ирэхэд ихэвчлэн хойд хэсгээр нь аялах магадлал өндөртэй.

Аймгийн зүгээс жуулчдыг аль болохоор аймгийн нутаг дэвсгэрт удаан байлгах, олон газраар аялуулах, аялалын нэмүү өртгийг шингээх сонирхол их байх нь мэдээж.

Иймээс тус замыг ашиглалтанд оруулснаар жуулчдын урсгалыг Өмнөговь аймгаас Өвөрхангай аймаг руу, мөн Хархорин сум гэх зэрэг хойд сумдаас урд сумд руу чиглүүлэх таатай нөхцөл

бүрдэнэ.

Үүнтэй холбогду олон улсын жуулчид, ялангуяа ОХУ-ын Тува, Сибирийн мужууд БНХАУ-ын зах зээл рүү гарах гарцыг идэвхтэй хайж байгаа, мөн дээрээс нь 2015 оноос ОХУ-ын зорчигчид визгүй орж ирэх учир жуулчдын тоо ихээхэн нэмэгдэх хандлагатай байна.



Зураг 2.19 ОХУ-БНХАУ-ыг холбосон шинэ босоо тэнхлэгийн боломж

Тус замыг барьж хөгжүүлэх, цаашид Хөвсгөл аймгийн болон Увс аймгийн хилийн гарц идэвхтэй ажиллаж, Хөвсгөл, Завхан аймаг засмал замаар холбогдох үед аажмаар Хөвсгөл аймгаас Өмнөговь аймаг хүртэл босоо тэнхлэгийн зам үүсэх бөгөөд ОХУ, БНХАУ-ыг холбосон шинэ босоо тэнхлэгийн боломж үүснэ.

Үүний тулд хүнд даацын машин тээврийн хэрэгслийг даах чадвартай тийм зам чухал байх болно.

Иймээс Арвайхээр-Шивээхүрэнгийн замыг эхний ээлжинд аймгийн зүгээс анхаарч, урьдчилсан ТЭЗҮ хийлгэх, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол улсын тээврийг хөгжүүлэх бодлогод хамааруулж оруулах нь чухал байх болно.

Цаашид тус замаас салаалж Өмнөговь аймгийн төвийн болон зүүн хэсэг рүү засмал замаар холбогдох нь чухал. Даланзадгад-Цогцэций-Ханбогд гэсэн Өмнөговь аймгийн өөрийн төлөвлөж байгаа зам гол үүргийг гүйцэтгэнэ.

Логистик

Зах зээлд эдийн засгийн үр ашгийг хангахад салбар доторх хийгээд салбаруудын хоорондох мэдээлэл, санхүү, материал хангамжийн тогтолоо зайлшгүй чухал.

Монгол улсын хэмжээнд өнөөдөр ХАА-н бүтээгдэхүүн болон түүхий эд бэлтгэл, бөөний болон жижиглэнгийн худалдааны логистик зах зээлийн орчинд зохицон ажиллахаар системлэг болж чадаагүй байна.

Мэдээлэл, санхүү, түүхий эд, тээвэрлэлтийн урсгалыг хамгийн оновчтойгоор ашиглан бараа, үйлчилгээ, баялгийг бүтээн хэрэглэгчдэд зөв цагт, хэрэгтэй үед, хамгийн бага зардлаар хүргэн үйлчлэх тогтолоо болох логистикийг зөвхөн Өвөрхангай аймаг төдийгүй улсын хэмжээнд хөгжүүлэхээр төлөвлөх үе тулгарч ирээд байгаа билээ.

Ийм үед Өвөрхангай аймгийн 6 аймагтай хиллэж байгаа давуу тал, Монгол улсын төв хэсэгт байрлах байршлын давуу талыг ашиглан хангайн бүсийн аймгуудыг хойноос урагшаа холбох, баруун аймгуудыг Улаанбаатар хот болон бусад аймгуудтай холбохоор ХАА-н түүхий эд ба бүтээгдэхүүн, бөөний худалдаа, агуулах, жижиглэн худалдаа, барилга, (агаар, авто зам гэх зэрэг), тээврийн логистикийг Өвөрхангай аймгийн Арвайхээр хотод төвлөрүүлэх боломжтой.

Өмнө хийгдсэн бодлогын судалгаанаас харахад ХАА-н агро паркийг Улаанбаатар хот руу чиглүүлэх байдлаар харуулсан бол газар зүйн байршил, худалдааны татах хүч, ХАА-н түүхий эд

бэлтгэлийн өнөөгийн байдал, цаашдын хандлагаас харахад бүс нутгийн хэмжээнд авч үзэх нь зайлшгүй.

Түүнчлэн барилгын болон аялал жуулчлалын логистик, тэр дундаа газар зүйн байршлаар хойноосоо урагшаа чиглэсэн, Шивээхүрэнгийн боомт хүрэх урсгал нь Арвайхээр хотоор дамжин өнгөрөх байдлаар төлөвлөгдөж байна.

Үүнээс гадна агуулах, тээврийн нэгжийн зардлыг бага байлгах зарчмаар зах зээлд ажиллах бол яах аргагүй хангайн бүсийн аймгуудын экспортын транзит Арвайхээр хотоор дамжих болно.

Худалдаа, бэлтгэлийн тогтолоо задарснаас хойш өнөөг хүртэл ХАА-н түүхий эд, бүтээгдэхүүний логистик тогтолооог улсын хэмжээнд нэгдсэн байдлаар төлөвлөөгүй байна.

ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэлийг шат дараалалтай хөгжүүлэхэд хугацаа, санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай.

Иймд нэн тэргүүнд малын гаралтай түүхий эд ба жижиглэн худалдааны агуулахын логистикийг хөгжүүлэхдээ Арвайхээр хотын төлөвлөлттэй уялдуулахаас гадна төрөлжилт, хослуулалтыг харгалзан тогтоох нь зайлшгүй.

Яагаад гэвэл, зах зээлийн өрсөлдөөнтэй орчинд ажиллах мэдээлэл, санхүү, түүхий эд, тээвэрлэлтийн үйл ажиллагааг иогч байдлаар шийдэх туршлага дутагдалтай хэвээр байна.

ХАА-н бүтээгдэхүүний бэлтгэлийн логистикийг хөгжүүлэхдээ:

нэгдүгээрт: байгаа нөөцөндөө түшиглэн хувиараа аж ахуй эрхлэгч буюу малчид, жижиг дунд аж ахуй эрхлэгчдэд тулгуурласан потенциалыг авч үзэх үү;

хоёрдугаарт: эсвэл “компани өсөх ёстой” гэсэн зарчмаар системтэй үүсгэх логистикоо аажимдаа томосгоно гэж үзэх үү;

гуравдугаарт: энэ хоёрыг хослуулах уу гэсэн логистикийг шинээр төлөвлөх суурь сонголтын асуудал тулгарч байна.

Өвөрхангай аймгийн хувьд худалдаа, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ мэдэгдэхүйц өсөж байгаа хандлагатай, харин тээвэр, холбооны хөгжлийн түвшин доогуур хэвээр байна.

Ийнхүү аймгийн зүгээс 6 аймагтай хиллэж байгаагаараа мэдээлэл, санхүү, материал хангамжийн логистик тогтолооог шинээр төлөвлөн хөгжүүлэх үе нь улсын хэмжээний, орчин үеийн логистикийг хөгжүүлэх үетэй давхцаж байгаа юм.

ХАА-н бэлтгэл, бөөний ба жижиглэн худалдаа, тээвэр, аялал жуулчлал, барилга, уул уурхайн логистикийг хөгжүүлэх нь аймгийн хувьд иоо шинэ бизнесийн чиглэл юм. Үүнээс гадна барилга, уул уурхайн салбарыг хүрээлэн буй орчны тэнцвэртэй байдлыг хангахуйцаар шинээр төлөвлөн хөгжүүлэх замын уулзвар дээр ирээд байна. Бусад салбарын хувьд сүүлийн хорин жилийн хугацаанд зах зээлийн гольдролд орж ажилласан ч одоо илүү сайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхээр зах зээлийн эрэлт рүү чиглэсэн инновацийн болон эдийн засгийн үр ашгийг хангах стратеги, үнэт зүйлсээ тодорхойлох болоод байна.

ХАА (малын гаралтай бүтээгдэхүүн ба чацаргана), аялал жуулчлал, барилгын салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх салбар, харин системтэй логистик болон уул уурхайн салбарыг урт хугацаанд хөгжүүлэх салбар гэж тодорхойлж болохоор байна.

2.2 Аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбарууд

Аймгийн зах зээлийн багтаамжийн судалгаанаас харахад Өвөрхангай аймаг зах зээлийн боломж, худалдаа хамралтын хувьд бүсийн бусад аймгуудаас нилээд сайн үзүүлэлттэй, өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна. Цаашид дунд болон урт хугацаанд аймгийг хөгжүүлэхэд юуны өмнө өөрийн нөөц боломжийг ашиглан дунд болон урт хугацаанд хөгжлийн бодлогын дагуу хэд хэдэн тэргүүлэх салбаруудад эхний ээлжинд улсын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг чиглүүлэх байна.

Үндэсний Статистикийн хорооноос боловсруулсан Монгол улсын 2010 оны 20 салбар бүхий салбар хоорондын балансын хүснэгтийг ашиглан хөрөнгө оруулалтын үржүүлэгчийг шинээр тооцлоо.

Тухайн нэг салбарт хөрөнгө оруулалт буюу эцсийн хэрэглээ нэгжээр нэмэгдэхэд өөрийн салбар болон бусад салбараас хэрэглэгдэх бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэх бөгөөд эдгээрийн нийлбэрийг хөрөнгө оруулалтын үржүүлэгч харуулна.

Өөрөөр хэлбэл тухайн салбарт 1.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл нийт эдийн засаг дахь үйлдвэрлэл хэдэн саяар нэмэгдэхийг энэхүү үржүүлэгч илэрхийлнэ.

Энэхүү үржүүлэгчийн утга их байх тусам тухайн салбарт хийх хөрөнгө оруулалтын нийт эдийн засгийн үр ашиг өндөр байна.

Салбарууд	Үржүүлэгчийн утга
1 Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт ан агнуур	1.78
2 Уул уурхай олборлолт	1.13
3 Боловсруулах үйлдвэрлэл	1.45
4 Барилга	1.38
5 Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	1.52
6 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.65
7 Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1.48
8 Мэдээлэл холбоо	1.82
9 Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2.13
10 Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.34
11 Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1.85
12 Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.99
13 Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа албан журмын нийгмийн хамгаалал	1.25
14 Боловсрол	1.10
15 Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1.11
16 Урлаг үзвэр тоглоом наадам	1.26
17 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.28

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэс, судалгааны багийн тооцоо

Эдгээр салбарын хувьд хөрөнгө оруулалтын үржүүлэгч нь 1.10 ба 2.13 хооронд хэлбэлзэж байна. Үүнээс үзэхэд дэд бүтцийг хөгжүүлэх, үйлчилгээ худалдаа, боловсруулах, мэдээлэл, харилцаа холбоо, хөдөө аж ахуйн хөрөнгө оруулалтын үр өгөөж өндөр байхаар тооцогдож байна.

Аймгийн эдийн засгийн нөөц, боломж болон зах зээлийн зээлийн багтаамжийн судалгаанаас үндэслэн Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбаруудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Хөдөө аж ахуйн салбар
2. Аялал жуулчлалын салбар
3. Худалдаа үйлчилгээ, тээвэр логистикийн салбар
4. Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн салбар
5. Уул, уурхайн салбар

Аймаг өөрийн нөөцөнд тулгуурлан аймаг дотроо хөгжүүлэх хөдөө аж ахуйн салбар, аялал жуулчлал, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбарыг дунд хугацаанд хөгжүүлэх, цаашилбал логистикийн илүү цогц дэд бүтэц, уул уурхайн салбарыг алс хэтдээ хөгжүүлэх салбар гэж тодорхойлж байна.

ГУРАВ. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ САЛБАРУУДЫГ ДУНД БА УРТ ХУГАЦААНД ХӨГЖҮҮЛЭХ ЗОРИЛТУУД

Аймгийн зах зээлийн хүрээнд гарч, бүсийн хэмжээнд, урт хугацаанд олон улсын зах зээлд аймгийн бүтээгдэхүүнийг экспортлох замаар эдийн засгийн өсөлтийг дэмжиж, аймгийн хөгжлийг түргэтгэх чиглэлийг барина.

Экспортод ХАА, үйлчилгээ (аялал жуулчлал, худалдаа), уул уурхай, эрчим хүч гэсэн салбарууд голлох үүргийг гүйцэтгэж, түүнийг дэмжсэн дэд бүтэц, тээвэр, логистикийг хөгжүүлнэ.

Төлөвлөлтийн урт хугацаанд Арвайхээр хот нь ХАА-н бүтээгдэхүүн, аялал жуулчлал, барилга, барилгын материалын худалдаагаар баруун болон хангайн бүсийг хангасан худалдаа үйлчилгээ, тээвэр логистикийн, Хархорин хот нь Монгол орны аялал жуулчлал, түүх соёлын төв хотууд болон хөгжих бөгөөд бусад сумдын хувьд дээрх 2 хотыг түшиглэн бие даан хөгжих эдийн засаг, санхүүгийн нөхцөл бүрдэнэ.

3.1. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР:

Аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбар ХАА-н салбарт дунд хугацаанд /2014-2018 он/ дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Зорилт 3.1.1. Мал аж ахуйн салбараас жилд дунджаар бэлтгэгдэж байгаа 27.8 мянган тонн мах, 30.6 сая литр сүү, 684.8 мянган ширхэг арьс шир, 2044.6 тонн ноос, ноолуур зэрэг бүтээгдэхүүн болон түүхий эдийн нэмүү өртөг шингээн боловсруулж, зах зээлд нийлүүлэх.

Дээрх дунд хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Мал, амьтаны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах замаар мал, амьтаны гоц халдварт өвчингүй тайван бүс болох;

- Арвайхээр суманд мах боловсруулах үйлдвэрийг түшиглэсэн малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийг байгуулах, олон улсын жишигт нийцсэн эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан мах экспортлох;

- Арвайхээр суманд ноос боловсруулах үйлдвэрийг түшиглэн ээрмэл, сүлжмэл, нэхмэлийн үйлдвэр байгуулах;

- Сум бүрт мал аж ахуйн түүхий эдийн анхан шатны тордолтын цэгүүдийг бий болгох;

- Мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн болон түүхий эд бэлтгэлийн тогтолцоонд зориулалтын хөргүүртэй тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх;

- Аймгийн нийт мал сүргийн бүтцийг боловсронгуй болгож, үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх, төв суурин газруудад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх;

- Фермүүдийг хөгжүүлэхтэй холбогдуулан тэжээл үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, таримал тэжээлийн одоогийн бэлтгэж байгаа хэмжээг нэмэгдүүлж, нийт малыг 15 хоног хүртэл нэмэгдэл тэжээлээр тэжээх нөөцийг бүрдүүлж, сумдад өвс, тэжээлийн нөөцийн сан, тэжээлийн цех байгуулах;

Зорилт 3.1.2. Газар тариалангийн салбарыг хөгжүүлэх замаар дотоодын нийт хэрэгцээт үр тарианы 70 хувийг, төмсний 130 хувийг, хүнсний ногооны 70 хувийг, жимс, жимсгэний 10 хувийг үйлдвэрлэх.

Дээрх дунд хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Аймгийн хэмжээнд байгаа нийт 15950 га атаршсан талбайг үр тариа, жимс жимсгэнэ, малын тэжээл тариалах чиглэлээр эдийн засгийн эргэлтэнд оруулах;

- Хархорин суманд Чацарганы үйлдвэрлэлийг каластер хэлбэрээр хөгжүүлэх, бусад сумдад чацаргана болон жимс, жимсгэнэ тариалалтыг нэмэгдүүлэх;

- Арвайхээр, Хархорин сумдад органик бордооны болон төмс дахин боловсруулах /цардуул, чипс/ үйлдвэр байгуулах;

- Газар тариалангийн салбарт орчин үеийн өндөр хүчин чадалтай, бүтээмжтэй техникийг нэвтрүүлж шинэчлэл хийх;

- Өрхийн тариалан эрхлэгчдэд болон аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлэх техник засвар үйлчилгээний дундын төвийг байгуулах;

- Тариалангийн бүс нутгуудад услалтын системийг хөгжүүлэх;

- Нарийнтээл, Төгрөг, Арвайхээр, Хархорин сумдад хүнсний ногооны төрөлжсөн зоорь, өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногоог боловсруулах, даршлах, савлах үйлдвэрийг байгуулах;

· Хархорин, Арвайхээр сумдад төмс, хүнсний ногооны механикжиж, автомажсан зорь, худалдааны төвүүдийг байгуулах;

· Газар тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан туслах аж ахуй /гахай, тахианы чиглэлийн ферм/-г хөгжүүлэх;

Зорилт 3.1.3. Салбарын хүний нөөцийг чадавхижуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Дээрх дунд хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

· Хөдөө аж ахуйн салбарын хэрэгцээт ажиллах хүчийг нарийвчлан судлаж, шаардлагатай мэргэжлийн боловсролтой ажилчдыг бэлтгэхэд зориулан курс, төвүүдийн үйл ажиллагааг дэмжих;

· Аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа, сургалтын агуулга, хөтөлбөрийг аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбаруудтай уялдуулан шинэчлэх;

· Улс, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратегийн төлөвлөгөө, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн логистик, хөдөө аж ахуйн салбарын дээд мэргэжилтэй хүний нөөцийг их, дээд сургуулиудтай хамтран бэлтгэх;

Аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбар ХАА-н салбарт урт хугацаанд /2014-2024 он/ дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Зорилт 3.1.4. Хөдөө аж ахуйн салбараас бэлтгэгдэж байгаа бүтээгдэхүүн болон түүхий эдийг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж экспортод гаргах

Дээрх урт хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ.

· Ноос, ноолууран бүтээгдэхүүний жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

· Төгрөг, Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Богд сумдад тэмээний аж ахуй байгуулан, аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх;

· Бүх сумдад махны чиглэлийн үхрийн, мах-ноосны чиглэлийн хонины эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, хилийн экспортын боомт руу чиглэсэн дэд бүтцийг байгуулах замаар махны экспортын хэмжээг нэмэгдүүлэх;

· Арвайхээр хотод арьс шир гүн боловсруулах үйлдвэр байгуулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

· Арвайхээр суманд сүү боловсруулах сүүлийн үеийн техник технологи бүхий үйлдвэр байгуулж, эцсийн бүтээгдэхүүнийг Улаанбаатар болон бусад аймгуудын зах зээлд гаргах;

· Арвайхээр хотыг баруун болон хангай бүсийн мал аж ахуй түүхий эд бэлтгэлийн логистик болгон хөгжүүлэх;

· Хархорин суманд сүүлийн үеийн техник, технологи бүхий гурил тэжээлийн үйлдвэр байгуулах;

3.2 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

Манай улс 2013 онд 417.8 мянга жуулчин хүлээн авсан бол 2015 онд 1.0 сая жуулчин, 2021 онд 3.1 сая жуулчин хүлээн авахаар төлөвлөж байна.

Монголд ирэх жуулчдын 30 доошгүй хувийг өөрийн аймагт ирүүлэх болон дайран өнгөрүүлэх зорилт тавибал 2024.0 онд 1 сая жуулчин хүлээн авах бэлтгэлийг төлөвлөх хэрэгтэй. Үүний тулд аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбар аялал жуулчлалын салбарт дунд хугацаанд /2014-2018 он/ дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Зорилт 3.2.1 Аймгийн аялал жуулчлалыг бүсчилэн хөгжүүлж, байгалийн болон түүх, соёлын дурсгалт газруудыг аялал жуулчлалын маршрутад хамруулах

Дээрх дунд хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд аймгийн аялал жуулчлал салбарыг дараах 4 маршрутаар хөгжүүлнэ. Үүнд:

· Орхоны хөндийн аялал жуулчлалын маршрут /байгаль, түүх, шашин мөргөлийн аялалын төрөлд хамаарна/ Чиглэл нь: Элсэн тасархай-Их, Бага Монгол уул, Ширээт цагаан нуур-Монгол орны төв хүйс-Хархорин, Эрдэнэзуу, Шанхын хийд-Хужирт сум-Үүртийн тохой-Төвхөн хийд-Улаан цутгалан-Хужирт сум

· Найман нуур буюу тусгай сонирхолын аялалын маршрут /энэ аялалыг зөвхөн мориор болон явганаар, мөн уулын дугуй мотоцикль, усан завиар хийвэл илүү тохиромжтой/

· Говийн болон баруун бүсийн сумдын аялалын маршрут /байгаль, түүх, соёл, палеонтологийн аялалын төрөл/ Чиглэл нь: Арвайхээр-Мазар хотын туурь-Өөш Шахлага-Ари богдын нуруу-Зүүн богд уул-Эмч элс-Таацын цагаан нуур-Өшгөгийн их залаа-Өни шилүүстэй-Шаргын тасархай-Шааман рашаан-Хубилай хааны цэргийн хотын туурь-Ширээт нуур-Арвайхээр

· Өндөр гэгээн Занабазарын түүхэн замналаар аялах маршрут /түүх, соёл, шашин мөргөлийн аялал/ Чиглэл нь: Элсэн тасархай-Их, Бага Монгол уул-Ширээт цагаан нуур-Монгол нутгийн хүйс цэг-Өндөр гэгээний Өвгөн суварга-Сэрүүн булаг-Есөнзүйл сум-Сангийн далай-Арвайхээр-Занабазарын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн-Бат-Өлзий сум-Улаан цутгалан-Төвхөн хийд-Баруун хүрээ- Эрдэнэзуу хийд-Хөгнө тарнийн хийд

Зорилт 3.2.2. Аялал жуулчлалын төрлүүд, түүний дотор тусгай сонирхолын, байгалийн, соёлын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх.

Дээрх дунд хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд аймаг орон нутгаас дараах соёлын болон спортын эвент арга хэмжээнүүдийг тогмол жил бүр зохион байгуулна. Үүнд:

· Арвайхээр-Хархорины аялал жуулчлалын бүсийн хэмжээнд жил болгон “Их Хаадын наадмыг” 7-8 дугаар сард зохион байгуулж үүний хүрээнд үргэлжилсэн соёлын, спортын болон музей үзмэрийн болон худалдаа яармагийн арга хэмжээ зохион байгуулах;

· Соёлын арга хэмжээ: Үүнд Эрдэнэ-Зуу хийдийн дэргэд тусгай түүхэн хэлбэртэй зуны театр байгуулж, Монгол урт, богино дуу, морин хуур болон бусад уламжлалт урлагийн концертыг, фестивалийг зохион байгуулах, Цам болон бусад уламжлалт урлагын үзүүлбэрүүдийг хийх (өдөр болгон тогтмол оройн цагаар), үүнд аймгийн хөгжимт драмын театр, сумын уран бүтээлчид, хүүхэд залуучууд, нутгийн сайн дурын урлагийн авьяастнуудыг татан оролцуулах (НИТАЖ), түүний мэдээллийг түгээх;

· Монгол эрийн гурван наадам иогиолборыг байгуулж, уламжлалт үндэсний бөх, морин уралдаан, сур харвааны тэмцээн, үзүүлэх тоглолтыг жуулчдад зориулан тогтмол зохион байгуулах;

· Жуулчдад зориулан аймгийн хөгжимт драмын театр монгол хаадын түүхийн тухай урлагийн тоглолт, концертыг наадмын турш зохион байгуулах

· Нүүдлийн соёл иргэншил, ахуй амьдралыг харуулсан аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг тогтсон хугацаанд тогтмол зохион байгуулж байх. /Адууны баяр, Сарлагын баяр гэх мэт/

· Мэргэжлийн аялал жуулчлалын боловсон хүчинг бэлтгэх ажлыг дэмжих, хэрэгцээг нарийвчлан судлах;

· Эдгээр арга хэмжээний талаар Монгол, Англи, Орос хэл дээр вэб сайт нээн ажиллуулж түүнд соёлын арга хэмжээ, спортын арга хэмжээ, музей үзмэрийн арга хэмжээний талаар тодорхой мэдээлэл, цаг хуваарийг тогтмол гаргаж шинэчилж байх;

Аймгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбар аялал жуулчлалыг кластер хэлбэрээр хөгжүүлэхийн тулд урт хугацаанд /2014-2024 он/ дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Зорилт 3.2.3 Жуулчдын зорин очих байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудын угтах орчныг тохижуулж, үйлчилгээг сайжруулах.

Дээрх урт хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ.

· “Хархорум XIII зуун” төслийг боловсруулан хэрэгжүүлж, Хархорин сумыг монгол орны аялал жуулчлал, түүх соёлын төв хот болгон хөгжүүлж, XIII зууны Эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийг ил музей болгох төслийг ХБНГУ-тай хамтран хэрэгжүүлэх;

· Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Төгрөг, Зүүнбаян-Улаан зэрэг сумдад нэн ховордсон дархан цаазат ан амьтадыг нутагшуулах, өсгөн үржүүлэх, амьдрах орчинг бүрдүүлж, тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх;

· Байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудыг улсын болон аймгийн тусгай хамгаалтанд авах;

· Орхоны хөндийд өндөр зэрэглэлийн жуулчны бааз байгуулах;

· Хужирт сумын халуун рашаан, Бат-Өлзий сумын Могойт, Тарагт сумын Хүрэмт халуун рашаануудыг түшиглэн жуулчдад зориулсан эмнэлэг, амралт, ардын уламжлалт эмчилгээ, массаж, саун зэрэг үйлчилгээнүүд бий болгохыг дэмжих

· Жуулчдад зориулсан боловсронгуй дэлгүүр, худалдааны төвүүдийг Арвайхээр, Хархорин сумдад байгуулах;

· Төвхөн хийд, Улаан цутгалан, Эрдэнэзуу хийдийн угтах орчныг шинээр зохион байгуулж, цэвэр, боловсон үйлчилгээтэй болох, орчин үеийн дэлгүүр, үйлчилгээний төвийг нээхийг дэмжих;

· Баруунбаян-Улаан суманд элсний сувилал байгуулж, аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх;

· Өвөрхангай аймгийн музейн үзмэрийг шинэчилэн баяжуулж, Их хаадын үеийн урлагийн үзүүлэн, галлерейг зохион байгуулж, түүнийг жуулчдад сурталчлах замаар Хархоринд ирж байгаа жуулчдыг үргэлжлүүлэн Арвайхээр хот рүү татах;

· Орхон голын Улаан цутгалан, Найман нуурыг түшиглэн уулын дугуй, мотоциклийн бартаат замын уралдаан тэмцээн, завиар уралдах рафтинг, өвлийн аялал жуулчлал зэргийг хөгжүүлэх;

· Жуулчдад зориулсан тээврийн үйлчилгээний төрөл, чанарыг дээшлүүлэх, нэмэгдүүлэх (түрээсийн уулын дугуй, мотоцикль, машин гм) зорилгоор Арвайхээр, Хархорин сумдад түрээсийн төвүүдийг байгуулах;

· Аялалын гол зам маршрутуудыг түшиглэн жуулчдын үдлэх, хоноглох газруудад мотелуудыг барьж байгуулах;

· Бүрд сумын нутаг дахь Монгол орны төв цэг, Ширээт цагаан нуур, Өлзийт сумын Сангийн далайд жуулчны бааз байгуулах;

Зорилт 3.2.4. Аймгийн аялал жуулчлалын бүс нутгуудын дэд бүтцийг хөгжүүлэх замаар

монгол орны аялал жуулчлалын төв төдийгүй ОХУ, БНХАУ-ыг холбосон аялал жуулчлалын босоо тэнхлэгийн төв болно.

Дээрх урт хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлнэ

- Аялал жуулчлал, тээвэр транзитын логистикийг сайжруулах зорилгоор Хархориныг түшиглэн олон улсын чанартай шинэ нисэх онгоцны буудал байгуулах;
- Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан чиглэлийн аялал жуулчлалын 90 км хатуу хучилттай авто зам барих төслийг хэрэгжүүлэх;
- Хархорин-Хужирт-Арвайхээр чиглэлийн 44 км хатуу хучилттай авто зам барих төслийг хэрэгжүүлэх
- Монгол улсын “Төв цэг” цогцолборыг улсын чанартай авто замтай хатуу хучилттай замаар холбох;
- Арвайхээр - Баянгол - Сайхан-Овоо - Цогт-Овоо чиглэлийн авто замын сүлжээг байгуулж, Өмнөговь аймаг болон БНХАУ-аас жуулчуудын урсгалыг татах;

3.3. ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭ, ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН САЛБАР

Өвөрхангай аймаг нь 6 аймагтай хиллэж байгаа монгол улсын төв хэсэгт байрлах байршлын давуу талаа ашиглан хангайн бүсийн аймгуудыг хойноос урагшаа холбох, баруун аймгуудыг Улаанбаатар хот болон бусад аймгуудтай холбохоор ХАА-н түүхий эд ба бүтээгдэхүүн, бөөний худалдаа, агуулах, жижиглэн худалдаа, барилга, барилгын материалын худалдаа, транзит тээврийн төв болон хөгжнө.

Үүний тулд худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн салбарт урт болон дунд хугацаанд дараах стратегийн зорилтыг дэвшүүлж байна.

Зорилт 3.3.1. Төр, хувийн түншлэлийн үндсэн дээр худалдаа, үйлчилгээ, тээвэр логистикийн салбарыг хөгжүүлнэ

Дээрх дунд хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Арвайхээр хотод ХАА-н бүтээгдэхүүн, түүхий эдийн, барилгын материалын агуулахын болон бөөний худалдаа байгуулахыг дэмжих
- Сумдад худалдаа, үйлчилгээ, ХАА-н чиглэлийн томоохон аж ахуй нэгж байгуулах санаачилгыг дэмжих;
- Бизнесийн үйл ажиллагааг дэмжих үүднээс төр хувийн түншлэлийг хөгжүүлж, аймгийн хөгжлийн зөвлөлийг байгуулж, түүнд хувийн хэвшлийн төлөөллийг оруулж аймгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хувийн хэвшлийн оролцоотой эрчимжүүлнэ;
- Бизнес төлөвлөлтийг сайжруулах, зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийн чадавхийг сайжруулах зорилгоор “Бизнес ширээ, бизнес инкубатор үйлчилгээ”-г бүрэн нэвтрүүлэх;
- Бизнесийн зөвшөөрөл олгодог нэг цонхны үйлчилгээний төрлийг олшруулна;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр хэрэгжих хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд концессийн гэрээний хэлбэрийг судлаж, нэвтрүүлэх;
- ЖДҮ-ийн хөнгөлөлттэй зээл, баталгаа, батлан даалт, санхүүгийн түрээс, даатгалын бодлогоор жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар хөдөлмөр эрхлэлт, ажлыг байрыг нэмэгдүүлж, ажлын байр бий болгосон аж ахуй нэгж, ажил олгогчдыг урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх;
- Хөгжлийн сан, орон нутгийн бондын боломжийг судлаж аймгийн тэргүүлэх чиглэлийн хөрөнгө оруулалттай уялдуулах;
- Бодлогын баримт бичгийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог иргэний нийгмийн оролцоотой хэрэгжүүлнэ;

Зорилт 3.3.2. Арвайхээр хотыг ХАА-н бүтээгдэхүүн түүхий эд бэлтгэл, бөөний худалдаа, агуулах, жижиглэн худалдаа, барилга, барилгын материалын худалдаа, транзит тээвэр, үйлчилгээний логистик төв болгон хөгжүүлнэ.

Дээрх стратегийн урт хугацааны /2014-2024 он/ зорилтыг хангахын тулд дараах төслүүдийг хэрэгжүүлнэ.

- Арвайхээр-Гучин-Ус-Шивээхүрэн чиглэлийн 485 км худалдаа, тээвэр, аялал жуулчлалын авто замын төслийг боловсруулан хэрэгжүүлэх
- Арвайхээр - Баянгол - Сайхан-Овоо - Цогт-Овоо чиглэлийн 300 км автозамыг байгуулж, Даланзадгад болон улмаар Даланзадгад - Цогтцэций, Өмнөговь аймгийн өөрийн төлөвлөж байгаа авто замын сүлжээтэй холбогдох;
- Мянганы замын босоо тэнхлэгийн замын сүлжээг хөгжүүлж, Хархорин-Арвайхээр-Гурвантэс-Шивээ хүрэн чиглэлийн засмал замыг түшиглэн аялал жуулчлалын үндэсний сүлжээг өргөтгөж, транзит тээврийг хөгжүүлж, аймгийн говийн сумуудыг хөгжлийг түргэсгэх, аймгийн экспортын хэмжээг нэмэгдүүлэх;

3.4. БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

Зорилт 3.4.1. Орон сууцжуулалтыг дэмжих, түүнд холбоотой барилгын материалын үйлдвэрлэлийг аймгийн нөөц бололцоонд түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, төлөвлөлтийн урт хугацаанд Баруун бүс, Хангай бүсийг холбосон гол барилгын материалын худалдаа, тээвэр транзитын төв болох.

Стратегийн зорилт 4.4.1-г хэрэгжүүлэхийн тулд дунд хугацаанд /2014-2018 он/ дараах барилгын материалын үйлдвэрүүдийг шинээр байгуулна.

дд	Үйлдвэрийн нэр	Хүчин чадал	Барих хугацаа	Ашиглах орд	Шаардагдах хөрөнгө оруулалт /сая төгрөг/	Санхүүжүүлэх эх үүсвэр
1	Төмөр бетон эдлэлийн үйлдвэр	1500 м ³	2015-2016	Онгийн голын элс хайрганы орд	-	Хувийн хөрөнгө оруулалт
2	MNS 0831:2001 стандартын Сийрмэг/ блок/ бетоны үйлдвэр	5000 м ³	2016-2018	Онгийн голын орд	2400.00	
3	Өнгөлгөөний чулууны үйлдвэр	10000 м ³	2016-2018	Хархорины саарал боржин	3800.00	
4	Эрдэс хөвөн	30000 м ³	2016-2018	Орхоны базальт	2600.00	

Үүний зэрэгцээ төлөвлөлтийн дунд хугацаанд дараах төслүүдийг хэрэгжүүлнэ.

- Арвайхээр хотод 35 МГВ хүчин чадалтай дулааны станцыг, дулааны магистраль шугамын хамт барих төслийг хэрэгжүүлэх;
- Хархорин, Арвайхээр хотын ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны нэгдсэн хороолол, хотхон байгуулах төслийг хэрэгжүүлэх;
- Арвайхээр хотын шинэ цэвэрлэх байгууламжийг байгуулах;
- Арвайхээр, Хархорин, Богд, Баянгол, Сант сумдын гэр хорооллын хувийн орон сууцтай айл өрхүүдийг инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбох;
- Дээрх стратегийн зорилтыг хангахын тулд урт хугацаанд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
 - Орон сууцны урт хугацааны хүү багатай моргижийн зээлийг банк, санхүүгийн байшууллага, олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;
 - Сумын төвүүдийг инженерийн нэгдсэн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжтай болгож орон сууцжуулах;
 - Гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбож барилгажуулах;
 - Барилгын материалын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнүүдийг хангайн болон баруун бүсийн аймгуудын зах зээлд нэвтрүүлэх;
 - Барилгын материал, барилгын салбарт дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ажиллах;

3.5 УУЛ УУРХАЙ САЛБАР

Зорилт 3.5.1. Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах хөрөнгийг бий болгох зорилгоор уул уурхайн ордуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах.

Үүний тулд төлөвлөлтийн дунд ба урт хугацаанд дараах ордуудад геологийн нарийвчилсан хайгуулаар нөөцийг шинэчилэн тогтоох ажлыг зохион байгуулах.

Үүнд:

- Нарийнтээл, Уянга сумдын нөөц өсөх ирээдүйтэй Таацын голын илрэл алт /660 кг/, Даргуатын сархиагийн алт /836.8 кг/-ыг нарийвчлан судлах;
- Бүрд, Баян-Өндөр сумдын нутаг дахь хар тугалга /14914.0 тн/, цайр /8273.9 тн/-ын нөөцийг геологийн нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжийг судлах, хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах;
- Нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжтой Арвайхээр сум Улаан толгойн илрэл /зэс 726845 тн, молибден 13219 тн/-ийг геологийн нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжийг судлах, хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах;
- Фосфоритийн ихээхэн нөөцтэй Тарагт сумын Хүрэн-Өндөрийн /4375460 тн/, Цагаан-Овоотын 19557 тн/ ордыг геологийн нарийвчилсан хайгуулаар өсгөх боломжийг судлах, хөрөнгө

оруулагчтай хамтран ажиллах;

- Нөөц өсөх ирээдүйтэй Баян-Өндөр сумын Зүүнбулагийн шатдаг занарын орд /130.0 сая тн/ -ыг нарийвчлан судлуулах;

- Төгрөг суманд газрын тосны нарийвчилсан хайгуулыг хийх;

Дээрх дунд хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

· Улсын болон аймгийн захиалгаар, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийх хайгуулын ажлыг дэмжих, нэмэгдүүлэх, үүнд газрын тос, занар болон бусад төрлийн хайгуулын ажлыг эрчимжүүлэх;

· Баянтээгийн уурхайг түшиглэн сэргээгдэх эрчим хүч, байгалийн хий, цахилгаан үйлдвэрлэж экспортлох боломжийг судлах;

· Уул уурхайн компаниудын харцулагын шалгуур үзүүлэлт, стандартыг боловсруулж, харцулагын зэрэглэлийг тогтоон жил бүр олон нийтэд мэдээлнэ;

· Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой уул уурхайн компаниудад компанийн засаглалын кодексийг бүрэн нэвтрүүлнэ;

· Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн санхүү болон үйл ажиллагааны тайланг ил тод болгож, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно;

Зорилт 3.5.2. Баянтээгийн уурхайг түшиглэсэн цахилгаан станцыг барьж, цаашид зөвхөн нүүрс биш, цахилгааны экспортыг нэмэгдүүлэн, Баруун, Хангай бүсийн найдвартай эрчим хүчний хангамжийг сайжруулж, уул уурхайн орд газар, аж үйлдвэрийн цогцолборуудыг түлш, эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах, эрчим хүчний экспортыг нэмэгдүүлэх /2014-2024 он/

Дээрх урт хугацааны стратегийн зорилтыг хангахын тулд дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд

· Баянтээгийн уурхайн ашиглалтын нөөцийг тогтоох хайгуулын ажлыг гүйцэтгүүлж, нөөцийг шинэчилэн тогтоох;

· Баянтээгийн уурхайн орчмын нүүрсний нөөцүүдийг нарийвчлан тогтоож эдийн засгийн эргэлтэнд оруулж бүтээгдэхүүнийг экспортлох;

· Баянтээгийн уурхайн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийх;

· Баянтээгийн уурхайг түшиглэсэн цахилгаан станци барих ажлын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;

ДӨРӨВ. АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА, МЕХАНИЗМ

Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегийн зорилго, зорилгод амжилттай хүрэхэд аймгийн өөрийн нөөцийг ашиглах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх явдал юм.

Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг Засаг дарга батлан жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжилтийг зохион байгуулна.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегийн хугацааны хэтийн төлөвийг 2014-2024 оноор тогтоох нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн төсөлтэй уялдаж, дунд хугацааг 2014-2018 оноор тогтоож, түүний дараагийн дунд хугацааны төлөвлөгөө нь 2018-2021, 2021-2024 оноор зохион байгуулагдах нь 2008 онд УИХ-аас баталсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, түүний хоёр дахь үе шаттай уялдаж байгаа.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегид тодорхойлсон арга хэмжээг аймгийн салбарын төлөвлөгөө, стратегид нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Мөн аймгаас Монгол Улсын хөгжлийн бодлого, Хангай бүсийн хөгжлийн бодлогыг шинэчлэхэд аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегитэй уялдуулан боловсруулж, түүнд гол саналыг тусгаж холбогдох байгууллагаар батлуулах нь хөгжлийн бодлогын баримт бичиг аймгийн болон үндэсний хэмжээнд нэгдсэн зорилготой байх сайн талтай.

Хөгжлийн дунд хугацааны стратегийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, аймгийн болон бүсийн хөгжлийн төлөвлөлтийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор цаашид Засаг даргын дэргэд аймгийн хөгжлийн зөвлөлийг байгуулан ажиллана.

Зөвлөлийг аймгийн Засаг дарга тэргүүлэх бөгөөд аймгаас төрөн гарсан УИХ, Засгийн газрын гишүүд, эрдэмтэн судлаачид, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Засаг дэргэдэх агентлагуудын удирдлага, аймгийн Монгол банкны салбарын удирдлага, томоохон бизнесийн төлөөлөл болон төрийн бус байгууллагуудын зөвлөлийн төлөөллөөс бүрдэнэ. Аймгийн Хөгжлийн зөвлөлийн ажиллах дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөө журмыг Засаг дарга батлана.

Хөгжлийн стратегийн хэрэгжилт, шинжилгээ, үнэлгээг жил тутам зөвлөлөөр хэлэлцэж тайлагнах нь төлөвлөгөөний хэрэгжилтэнд мониторинг хийх тогтолооо үүсгэхэд чухал ач холбогдолтой.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх арга механизмыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

· Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн төслүүдэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, нөөцийн хуваарилалтыг оновчтой хийх;

· Аймгийн аж ахуй нэгжүүдийг нэгдэх, хөрөнгө хорших замаар үйл ажиллагаагаа өргөтгөхийг дэмжих;

· Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг тэргүүлэх салбаруудад татах ажлыг зохион байгуулах;

· Аймгийн санхүүгийн корпорацн байгуулж, хөгжлийн сан, бонд гаргах, зээлийн баталгаа гаргах замаар эдийн засгийн тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулалт хийх;

· Олон улсын байгууллагуудын урт хугацаатай зээл, гадаадын хөрөнгө оруулалтыг татах;

· Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг оруулсан хөрөнгийн хэмжээнээс хамааруулан зарим төрлийн татварын хөнгөлөлт үзүүлэх;

· Сумдыг бие даан хөгжих эдийн засаг, төсөв санхүүгийн нөхцөл боломжийг олгох зэрэг юм.

Хэрэгжилтийн хэмжүүр, шалгуур үзүүлэлт

Аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг бодитой хэрэгжүүлэхийн тулд тасралтгүй, тодорхой давтамжтай үнэлгээ хийж, хянах төдийгүй орологч талуудыг ойлголт нэгтэй байлгаж, зорилгодоо хүрэх шаардлагатай тохируулга, засвар өөрчлөлтийг тухай бүр аймгийн ИТХ-д оруулан шийдвэрлүүлж байна.

Иймд аймгийн Засаг даргын Тамгын газар стратегийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг үнэлж, жил бүр тайлагнаж байна.

Стратегийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх түлхүүр үзүүлэлтийг аймгийн Хөгжлийн зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэнэ.

Харин хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт амжилттай юу үгүй юү гэдгийг хэмжих хэмжүүр нь:

· Орон нутгийн иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг аймгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтэнд оролцож буй байдал, тэдний орлогын дээшлэлт

· Орон нутгийн ба улсын төсөвт төвлөрүүлж буй татварын хэмжээ, төвлөрүүлсэн

хураамжийн хэмжээ

- Эдийн засгийн болон нийгмийн дэд бүтцийн хангамжийн үзүүлэлтүүд
- Бизнес эрхлэгчдийн сэтгэл ханамж, бүтээж байгаа үнэ цэнэ (ДНБ) зэрэг үзүүлэлт

БОДИТ ДНБ

- 2013 онд ДНБ 107.0 тэрбум төгрөг (2005 оны зэрэгцүүлэх үнээр),
- 2015 онд ДНБ 118.0 тэрбум (2005 оны зэрэгцүүлэх үнээр),
- 2018 онд ДНБ 137.0 тэрбум төгрөг (2005 оны зэрэгцүүлэх үнээр) буюу 30 хувийн бодит өсөлттэй байх,
- 2021 онд ДНБ 160.0 тэрбум төгрөг (2005 оны зэрэгцүүлэх үнээр) буюу 40 хувийн бодит өсөлттэй байх
- 2024 онд ДНБ 183.0 тэрбум төгрөг (2005 оны зэрэгцүүлэх үнээр) буюу 74 хувийн бодит өсөлттэй байх эрчимтэй өсөлтийн прогноз хандлагыг тооцож байна.

НЭРЛЭСЭН ДНБ

- 2013 онд аймгийн ДНБ 307.0 тэрбум төгрөг,
 - 2015 онд аймгийн ДНБ 424.0 - 458.0 тэрбум төгрөг,
 - 2018 онд аймгийн ДНБ 689.0 - 834.0 тэрбум төгрөг,
 - 2021 онд аймгийн ДНБ 1019.0 их наяд төгрөгт хүрэх,
 - 2024 онд аймгийн ДНБ 1.8 их наяд төгрөг орчим болох төлөвтэй байна.
- Бизнесийн идэвхжилийн үзүүлэлт (хөрөнгө оруулалт, борлуулалт, гм) орно.
- Орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшний дээшлэлтийг хэмжихдээ тогтмол давтамжтай тоон мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхээр түүвэр судалгааг 2 жил тутамд явуулж байна. Энэ судалгаагаар орон нутгийн иргэдийн бизнест хандах хандлагын өөрчлөлтийг тодорхойлно.

Аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх гол оролцогч талууд, тэдгээрийн үүрэг, функц

Байгууллага, нэгж	Үүрэг, функц
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)	Өвөрхангай аймагт сонгосон салбар, кластерийг хөгжүүлэх зорилгын хүрээнд ИТХ бүх шатны шийдвэр гаргагч нарт кластерийн ач холбогдлыг таниулж, улмаар бодлогын хэрэгсэл болгон ашиглана.
Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)	Аймагт бизнес хөгжүүлэх зорилгын хүрээнд 1) Кластертай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг хангах; 2) Аймгийн төсвөөс бизнест дэмжлэг үзүүлэх жилийн төсөв батлах; 3) Нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэхийн тулд шаардлагатай арга хэмжээнүүдийг авах, жишээлбэл, олон улсын шаардлага хангасан онгоцны буудал барих, логистик хөгжүүлэх, хүний нөөцийн асуудал г. м; 4) ЖДҮ-ийн шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн орчинг бүрдүүлэх зэрэг ажлыг манлайлна.
Өвөрхангай аймгийн Нутгийн зөвлөл	Өвөрхангай аймгийн хөгжлийг дэмжих зорилгынхоо хүрээнд аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг гишүүдээрээ дамжуулан сурталчилж улмаар бүх талын дэмжлэгийг үзүүлнэ.
Өвөрхангай аймгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим	Гишүүд болон бизнес эрхлэгчдийн төлөө аймгийн эдийн засаг болон бизнесийн орчин, нөхцлийг сайжруулахын төлөө ажиллана.
Аймгийн мэргэжлийн холбоод	Гол оролцогч талуудыг нэгтгэсэн ашгийн бус төрийн бус байгууллага нь: 1) Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлогын баримт бичиг, дүрэм журамд саналаа өгч, шийдвэр гаргагч байгууллагуудтай хамтран ажилах; 2) Аймгийн бүтээгдэхүүн, үзвэр үйлчилгээг сурталчилах; 3) Гишүүдийн сонирхол, эрх ашгийг холбогдох байгууллагуудад таниулж хамгаалах; 4) Аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг мэргэжлийн болон ёс суртахууны өндөр хэмжүүрийг дагаж мөрдүүлэх; 5) Бараа, үйлчилгээ авсан хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах; 6) Гишүүддээ зориулж кластерийн талаар зөвлөгөө өгч, сургалт явуулах; 7) Хүрээлэн буй орчинд ээлтэй мөн нутгийн өв уламжлалыг дээдэлсэн үйл ажиллагаа зэргийг явуулна.
Хувийн хэвшил	1) Байгаль орчинд ээлтэй, нутгийн соёл, уламжлалыг хадгалсан тогтвортой бүтээгдэхүүн үйлчилгээг байнга, тасралтгүй хөгжүүлэх; 2) Аймгийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг таниулан сурталчилах; 3) Шударга өрсөлдөөний зарчмаар аймгийн нэмүү өртгийн сүлжээг бэхжүүлэх; 4) Орон нутагт ажлын байр бий болгох; 5) Өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх үүднээс холбогдох сургалт, зөвлөгөөнд идэвхтэй оролцох, 6) Нийгмийн үүргээ ухамсарласан хариуцлагатай татвар төлөгч байх зорилго бүхий зарчмын дагуу ажиллана.
Холбоотой ба бие биенийгээ дэмжин ажиллах хувийн хэвшил	1) Өөрийн сүлжээнд өөрийн чиг үүргийн дагуу үйлчилгээ үзүүлэх; 2) Кластерийн ойлголтыг ухуулан таниулах; 3) Гишүүд, хууль тогтоомжийн байгууллага, олон нийтэд сургалтын боломж олгох, цаг үеийн мэдээллийг цаг алдалгүй өгөх; 4) Гишүүддээ эдийн засгийн болон бусад үйлчилгээг өргөн цар хүрээтэй хүртээж өр өгөөжийг нь нэмэгдүүлэх; 5) Аймагт үйлдвэрлэх бараа, үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.
Малчдын бүлэг, нөхөрлөл	Зорилго нэг малчид болон малчдын бүлгүүдийг нэгтгэсэн ашгийн төлөө нөхөрлөл нь 1) Уламжлалт монгол ахуйг илэрхийлсэн малчин хүний бодит амьдралыг таниулсан бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх; 2) Мальн гаралтай бүтээгдэхүүнээс олох орлогыг нэмэгдүүлэхдээ нөөцийн зөв ашиглалтыг гишүүддээ сайн ойлгуулах; 3) Мальн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн тэлэлт нь уламжлалт амьдралын хэв маягт харшлахгүй байх тал дээр анхаарах; 4) Нийлүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь Монгол хүний эрүүл мэндийг хамгаалах,дотоодын бүтээгдэхүүний эрэлтийг өсгөхийн төлөө үйл ажиллагаа руу чиглэнэ.
Банк, санхүүгийн байгууллага	Аймгийн эдийн загийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг дэмжих зорилгоор санхүүгийн арга хэрэгсэл, зээлийн багц болон бусад хэрэгсэлийн талаар оролцогч талуудад тогтмол сургалт явуулж зөвлөгөө өгнө. ЖДҮ, өрхийн үйлдвэрлэлд олгох зээлийг экспорт руу илүү чиглүүлэхэд анхаарна.
Ажил олгогчдын холбоо	Нийгмийн бүх давхаргын төлөөллийг ажлын байраар хангах зорилгоор мэргэшил олгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, холбогдох хууль эрх зүйн сургалт зөвлөгөөнд олон нийтийг өргөн хамруулна.

Хөдөө аж ахуй эрхлэгчдийн холбоо	Аймгийн малын гаралтай бүтээгдэхүүн, чацарганы өрсөлдөх чадварыг бэхжүүлэх үүднээс зочид буудал, зоогийн газруудад зах зээлийн үнээр эрүүл хүнсээр хангахаас гадна нийлүүлж буй хоол хүнсний төрөл зүйлийг нэмэгдүүлнэ. ЖДҮ болон хувиараа аж ахуй эрхлэгчдийг сургалт, зөвлөгөөнд тогтмол хамруулна.
Тусгай хамгаалалттай газрын удирдлага	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн олноор байрлах тусгай хамгаалалттай газрын удирдлага тус байгалийн нөөцийг зөв зохистой эдийн засгийн эргэлтэнд оруулахаас гадна онгон дагшин төрхийг нь хадгалах, доройтсон газар нутгийг сэргээх зэрэг хамгаалалтын үйл ажиллагааг тууштай явуулна. Олон нийтийн хүрээлэн буй орчны талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор танилцах сургалт, семинарыг явуулна.
Капиталын хөрөнгө оруулагчид	Сонгосон салбарын үйл ажиллагаатай холбоотой тоног төхөөрөмж, хэрэгслийг нийлүүлж, орон нутагт бизнесээс олох орлогыг нэмэгдүүлэх, санхүүгийн хөнгөлөлттэй нөхцлийг таниулах, аймгийн зах зээлийн өрсөлдөөнт орчныг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.
Сургалтын байгууллага	Аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан бизнест шаардлагатай инженер, техникийн ажилтан, мэргэжлийн ур чадвартай ажиллагчдыг бэлтгэхэд тусална.
Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага	Аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан бизнест шаардлагатай техник, технологи, стандартын судалгаа, шинжилгээг гэрээний дагуу хийж гүйцэтгэн, бодлогын үр нөлөөг шинжилнэ.

ТАВ. ХАВСРАЛТ АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Тайлан, хөтөлбөрүүд

- Монгол Улсын Засгийн газар, 2013 он, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт: Үндэсний тав дахь илтгэл
- ҮХШХ, 2011, “Хархорум 13 дугаар зуун” төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа
- ЗДТГ, ИТХ, 2005, Өвөрхангай аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө
- ЗДТГ, ИТХ, 2007, Өвөрхангай аймгийн хөгжлийн бодлого 2015 он хүртэл
- ЗДТГ, ИТХ, 2009, Нарийнтээл сумын эдийн засгийн хөгжлийн цогцолбор төлөвлөгөө 2009-2020
- ЗДТГ, ИТХ, 2010, Гучин-Ус сумын хөгжлийн стратеги, төлөвлөгөө 2010-2020
- ЗДТГ, ИТХ, 2012, Арвайхээр сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө 2012-2022
- ЗДТГ, ИТХ, 2012, Уянга сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө 2014-2023
- ЗДТГ, ИТХ, 2013, Бүрд сумын хөгжлийн төлөвлөгөө 2014-2024
- ЗДТГ, ИТХ, 2013, Тарагт сумын хөгжлийн стратеги төлөвлөгөө 2013-2023
- ЗДТГ, ИТХ, 2014, Баян-Өндөр сумын хөгжлийн төлөвлөгөө 2014-2023
- ЗДТГ, ИТХ, 2014, Богд сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө 2012-2023
- ЗДТГ, ИТХ, 2014, Зүүнбаян-Улаан сумын хөгжлийн төлөвлөгөө 2014-2024
- ЗДТГ, ИТХ, 2014, Өлзийт сумын хөгжлийн төлөвлөгөө 2014-2023
- ЗДТГ, ИТХ, 2014, Хархорин сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө 2014-2024
- ЗДТГ, ИТХ, 2014, Төгрөг сумын эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө 2014-2023
- НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр ба ҮСХ, 2011 он, Мянганы хөгжлийн зорилтууд ба ядуурлын зураглал 2011”
- Дэд бүтцийн хөгжлийн яам, ЖАЙКА, 2006, Аялал жуулчлалын хөгжлийн стратеги төлөвлөгөө 2006-2010, “Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал (НИТАЖ)”
- Дэд бүтцийн хөгжлийн яам, ЖАЙКА, 1999, Аялал жуулчлалын хөгжлийн мастер төлөвлөгөө
- ССАЖЯ, 2012, Бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө: Аялал жуулчлалын салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтцийг бий болгож ажиллуулах
 - Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, 2011 он, Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн үндэсний дөрөв дэх тайлан
 - Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, 2011, “Хархорум 13-р зуун” төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа
 - Өвөрхангай аймгийн ИТХ ба ЗДТГ, 2007, Өвөрхангай аймгийн хөгжлийн хөтөлбөр (2007-2015 он) Ном, товхимол, судалгааны эмхэтгэл
 - Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Монгол улс, Аймгуудын өрсөлдөх чадварын анхдугаар тайлан 2012, УБ., 2012 он, хуудас 90-91